



БОДЛОГЫН
ИННОВАЦИЙН
ХҮРЭЭЛЭН



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

**ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГЭРЭЭ БЭЛТГЭХ, ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОХ,
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ НЬ**

ЦАХИМ ГАРЫН АВЛАГА

ГАРЧИГ

УДИРТГАЛ.....	4
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР.....	7
ОРОН НУТАГ, КОМПАНИУДЫН ХООРОНДЫН ХАРИЛЦАА БА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ.....	12
ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ.....	18
ГЭРЭЭНИЙ БЭЛТГЭЛИЙН ҮЕ ШАТ.....	22
Орон нутгийн гэрээгээр шийдвэрлэхийг зорьж буй асуудлаа тодорхойлох.....	23
Уул уурхайн төсөл хэрэгжих шалтгаан, түүний ач холбогдлыг ойлгох.....	24
Орон нутгийг хэн төлөөлөх, нутгийнхан гэж хэнийг ойлгохыг тодорхойлох.....	26
Гэрээ байгуулах ажлын хэсгийг үр дүнтэй зохион байгуулах.....	31
Гэрээ байгуулах, хэрэгжүүлэх үйл явцад хяналт тавих.....	35
Мэдээллийг үр дүнтэй ашиглах.....	37
Олон нийтийн оролцоог хангах.....	43
Гэрээ байгуулахад баримтлах зарчмуудаа тодорхойлох.....	51
Хяналтын хуудас: Гэрээ байгуулахад бэлэн үү?.....	52

ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОХ ҮЕ ШАТ	54
Ойлголцол, итгэлцэл бий болгох.....	54
Хэлэлцэн тохиролцох стратеги	57
Гэрээнд тусгах суурь асуудлуудыг ойлгох.....	61
ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	72
Мэдээлэл цуглуулах ба солилцох.....	72
Гэрээний зорилго, үүрэг амлалт болон хийгдэж буй ажлын уялдаа	73
Гэрээний хэрэгжилтийг дэмжих механизм.....	74
Гэрээний биелэлтийн хяналт.....	75
ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА	77
Гэрээний нэгдмэл байдал.....	79
Гэрээний хүчин төгөлдөр байдал ба өөрчлөлт.....	79
Гэрээний гүйцэтгэл ба хариуцлага	81
ЭХ СУРВАЛЖУУДЫН ЖАГСААЛТ	82

УДИРТГАЛ



Д.Эрдэнэчимэг “Гарын авлагын тухай”

<https://www.youtube.com/watch?v=Tg3bpnY1KO4>

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэхдээ орон нутгийн гэрээ байгуулж, тухайн нутаг орны иргэд, нутгийн захиргааны байгууллагатай харилцан итгэлцэл бий болгон хамтран ажиллах замаар орон нутгийн хөгжилд зохих хувь нэмэр оруулдаг олон улсын болон манай улсын туршлага цөөнгүй байна.

Эрдэс баялаг ихтэй улс орнуудад олборлох компани, иргэдийн хооронд гэрээ байгуулах хууль эрх зүйн шаардлага, тогтсон уламжлал аль аль нь бий. Тухайлбал Австрали, Канад, ОХУ зэрэг улсуудад уугуул иргэдийн эзэмшлийн газар нутагт компаниуд үйл ажиллагаа явуулахдаа хамтын ажиллагаагаа гэрээгээр зохицуулж ирсэн байдаг. Канадад “нөлөөлөл, үр ашгийн” хэмээн нэрлэгддэг ийм гэрээ байгуулах үүргийг уугуул иргэдийн эзэмшил газар нутагт үйл ажиллагаа явуулах тохиолдол бүрд тэдэнтэй зөвшилцөх хуулийн шаардлагын хүрээнд хэрэгжүүлдэг.

Монгол Улсад Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д зааснаар хайгуулын болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн захиргаатай харилцахдаа дараах үүргийг хүлээнэ:

“Орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж байгаль орчныг хамгаалах, уурхай байгуулах, уурхай байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр гэрээ байгуулж ажиллана”.

Түүнчлэн, Газрын тосны тухай хуулийн 11.2.17-д “... байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах”-ыг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг болгон хуульчилжээ.

Хуулийн эдгээр заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор 2016 оны тавдугаар сард Монгол Улсын Засгийн газар “Байгаль хамгаалах, уурхайтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, үйлдвэр байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх гэрээний загвар”¹-ыг баталсан.

Уул уурхайн компаниуд орон нутгийн захиргаатай хамтран ажиллах гэрээ байгуулах энэхүү үүргийг 2006 онд анх хуульчилснаас хойш чамгүй туршлага, сургамж хуримтлагджээ. Гэвч орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулах чадавх сул, мэдлэг ойлголт бага, байгуулахдаа дутуу дулимаг хандаж буйг засаж сайжруулах шаардлагатай байна.

Иймд энэхүү гарын авлагаар орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний тухай үндэсний ба олон улсын судалгаанд суурилсан зөвлөмж, жишээ, бие даан мэдээлэл авах эх сурвалжуудыг танилцуулж байна. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулахад тухайн нутгийнхан

¹ Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан газар “Байгаль хамгаалах, уурхайтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, үйлдвэр байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх гэрээний загвар <https://www.legalinfo.mn/annex/details/7245?lawid=11852>

бэлтгэлээ хангах, хэлэлцэх, үр дүнг нь хянахад анхаарах асуудлуудын талаар мэдээлэл өгөхийг зорьж энэхүү гарын авлагыг бэлтгэн гаргав. Уг гарын авлага гэрээ байгуулах үүрэг бүхий орон нутгийн удирдлага, нутгийн хөгжлийн төлөө ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд, гэрээний үр өгөөжийг хүртэх учиртай нутгийн иргэдэд голчлон зориулагдсан болно. Урьдчилан анхааруулахад энэхүү гарын авлагад тодорхой гэрээ байгуулахад үүсэх эрх зүйн үүрэг хариуцлагыг нарийвчлан тайлбарлахгүй бөгөөд мэргэшсэн хуульч, эрх зүйчдээс авах шаардлагатай зөвлөгөөг орлохгүй болно.

Уг гарын авлага хамтын ажиллагааны гэрээ байгуулах үндсэн гурван үе шат буюу (i) гэрээ бэлтгэх, (ii) хэлэлцэн тохиролцох, (iii) хэрэгжүүлэхэд орон нутгийнхны хувьд анхаарах асуудлуудыг танилцуулах бүтэцтэйгээр бэлтгэгдлээ. Үүнд нэг талаас, тухайн үе шатанд авч хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн эрэмбэ дараалал, нөгөө талаас хөндөгдөх асуудлуудын агуулга, мөн чанарын талаар мэдээлэл өгөхийг зорив. Үүнээс гадна мэргэжилтнүүдийн видео танилцуулга, тайлбар, дүрс мэдээлэл, олон улсын болон дотоодын туршлагын шигтгээ зэргийг багтаасан болно.

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Ашиг хуваалцах – Орон нутаг тухайн уурхай буюу төслөөс олж буй компанийн цэвэр ашгаас хүртэх явдал.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу роялти - Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүнд ногдуулан тооцож буй төлбөр. Нөөц ашигласны төлбөр нь тухайн байгалийн баялгийн өмчлөгч болох төрд олгож буй нөхөн олговор юм.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ - Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг хэлнэ.

Газрын төлбөр - Газар эзэмшиж, ашигласны төлөө төлөх төлбөр.

Гомдол шийдвэрлэх механизм – Тухайн төслөөс үүдэж буй сөрөг нөлөөллийн талаарх аливаа гомдол, шүүмжийг шийдвэрлэх арга зам хайх үйл явц.

Гэрээ - Хоёр буюу түүнээс дээш талууд тохиролцож хуулийн дагуу үйлдсэн баримт бичиг.

Гэрээний талууд – Өөр нэг этгээдтэй гэрээ байгуулахаар тохиролцсон аж ахуйн нэгж, иргэн, байгууллага.

Гэрээний хугацаа – Гэрээ хүчинтэй байх хугацаа.

Дэд бүтэц – Тухайн төслийн үйл ажиллагааг явуулахад эсхүл хот сууриныг хөгжүүлэхэд шаардлагатай барилга, эрчим хүч, цэвэр бохир усны байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээ зэрэг инженерийн бүтцийг хэлнэ. Нийгмийн дэд бүтэц гэж соёл, боловсрол, эрүүл мэндийн барилга байгууламжийг хамруулан ойлгодог.

Захиргааны шийдвэр - Нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагаа.

Зөвшөөрөл, Тусгай зөвшөөрөл – Хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас олгосон, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгож буй тусгай баримт бичиг.

Компани - Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээд.

Мэргэшсэн зөвлөх – Үндэсний болон олон улсын эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн этгээд.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ - Тухайн төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй нийгмийн бодит болон боломжит нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг хэлнэ.

Нийгмийн лиценз - Аливаа уул уурхайн төслөөс буй болох хамтын үр өгөөжийн тухай төсөөллөөс хамаарч орон нутгийн иргэд тухайн компанийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг дэмжсэн хандлага буюу түр зөвшөөрөл.

Нөлөөллийн бүс – Тухайн төслийн үйл ажиллагааны улмаас учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаварт шууд болон шууд бусаар өртөж буй иргэд болон айл өрхүүд, мөн газар нутгийг ойлгоно.

Нээлттэй сонголт - Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах үйл ажиллагаа.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ - Холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулсан гэрээ.

ОУИТБС буюу Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга - Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий зэрэг байгалийн баялгаас орж буй орлого, түүний зарцуулалтыг нийтэд ил тод болгоход чиглэсэн олон улсын санаачилга юм. Уг санаачилгын дагуу нэг талаас олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд улс, орон нутгийн төсөвт төлсөн бүх татвар, төлбөр, хураамж, хандив тусламжаа тайлагнаж, нөгөө талаас Засгийн газар тэдгээр компаниудаас

хүлээн авсан бүх орлогоо тайлагнаж, ийнхүү хоёр талаас ирүүлсэн тайланг хараат бус, хөндлөнгийн аудитын байгууллага тулган баталгаажуулж, зөрүүг шалган олон нийтэд ил тод болгодог.

Сайн дурын үндсэн дээр мэдээлэлд суурилан чөлөөтэйгөөр, урьдчилж өгсөн зөвшөөрөл – газар нутагт нь төсөл хэрэгжүүлэх, баялгийг нь ашиглах бол тухайн нутгийн уугуул иргэдтэй заавал урьдчилан зөвшилцөх, тэдгээрийн оролцоотойгоор шийдвэр гаргах үйл явц бөгөөд НҮБ-ын Уугуул иргэдийн эрхийн тунхаглалаар баталгаажсан эрх юм. Ингэхдээ уугуул иргэд шийдвэрээ гаргахад шаардлагатай бүх мэдээллийг урьдчилж өгөх, саналаа бэлтгэх хангалттай хугацаа олгох, гаргах шийдвэрт нь аливаа хэлбэрээр нөлөөлөхгүй, ямар нэгэн дарамт шахалт үзүүлэхгүй байх ёстой.

Сонсох ажиллагаа - Захиргааны акт болон захиргааны гэрээг байгуулахад эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгох үйл ажиллагаа.

Тусгай зөвшөөрөл бүхий талбай – Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай.

Усны төлбөр – Ус ашигласны төлөө төлөх төлбөр.

Хөрөнгө оруулагч - Тухайн төсөлд хөрөнгө оруулалт хийсэн гадаад, дотоодын хувь хүн болон хуулийн этгээд.


Хөрөнгө оруулалт - Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгө.

Хэлэлцээ - Ямар нэгэн учир явдлыг шийдвэрлэх аргын тухай хоёр болон түүнээс дээш этгээд зөвлөн хэлэлцэх явдал.

Хяналт мониторинг – Аливаа төслийн үйл ажиллагаа, гүйцэтгэл болон үр дүнг тасралтгүй үнэлэх үйл явц.

ОРОН НУТАГ, КОМПАНИУДЫН ХООРОНДЫН ХАРИЛЦАА БА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

Уул уурхайн төсөл тухайн орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чухал хувь нэмэр оруулдаг. Зэс, молибдений Эрдэнэт үйлдвэр байгуулагдсанаар Эрдэнэт хот сүндэрлэн босож, дөчөөд жилийн туршид орон нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Сүүлийн жилүүдэд уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж ирсэн Өмнөговь аймагт олон бизнес шинээр цэцэглэж, тус аймгийн иргэдийн орлого нэмэгдэн ядуурлаас гарч буйг статистик мэдээ харуулдаг. Гэхдээ тухайн газар орон нутгуудад байгаль орчны доройтол, нийгмийн хүндрэлтэй асуудлууд, хот байгуулалт, суурьшилт шилжилттэй холбоотой олон бэрхшээл тулгарахын сацуу уламжлалт мал аж ахуй зэрэг бусад салбарын хөгжилтэй холбоотой хүндрэл үүссээр байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд төр засгийн зүгээс алсын хараатай, дорвитой бодлого явуулах шаардлагатай. Харин ийм бодлого нь уул уурхайн компаниуд, орон нутгийн удирдлагын хамтын ажиллагаанд түшиглэсэн тохиолдолд амжилттай байх боломжтойг олон жишээ харуулдаг. Түүнчлэн, энэхүү хамтын ажиллагаа нь талуудын ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд тухайн орон нутгийн эрх ашгийг судлан ойлгож, харилцан буулт хийх замаар хамтран ажиллахыг шаарддаг.



Схем 1. Төр, орон нутаг, уул уурхайн компани (талууд)-ийн харилцаа

Нутгийн засаг захиргаа, иргэдийн хувьд уул уурхайн үйл ажиллагааг тухайн орон нутгийн хөгжилд зарцуулах хөрөнгийн орлогын эх үүсвэр гэж харах нь элбэг. Уул уурхайн компаниудаас татвар болон бусад хэлбэрээр цуглуулах хөрөнгийг аль болох их байлгах; нөгөө талаас, цуглуулсан хөрөнгөө үр дүнтэй зарцуулах, сацуу шинэ боломжийг үр дүнтэй ашиглах зэрэг сорилтууд орон нутгийнхны өмнө тулгардаг байна. Үүнд ялангуяа орон нутагт шинээр бизнес бий болгох, тухайлбал ханган нийлүүлэгч компаниудыг орон нутгаас сонгох, нутгийн хөгжилд уул уурхайн компаниуд анхаарахыг нутгийнхан илүүтэй хүсдэг. Уламжлалт аж ахуй, тухайлбал хөдөө аж ахуйг цаашид тогтвортой эрхлэхэд уул уурхайн үйл ажиллагаа ихэнхдээ хүндрэл учруулах тул нутгийнхны зохицон амьдрах орчныг бүрдүүлэхийг шаардах нөхцөл байдал ч үүсэж мэднэ. Түүнчлэн, уул уурхай нь байгаль орчны асуудлуудыг дагуулах тул сөрөг нөлөөллийг аль болох багасгах, нөхөн сэргээлт хийлгэх явдлыг баталгаажуулахад орон нутгийнхан илүүтэй анхаарал хандуулдаг. Цаашилбал, уул уурхайн томоохон төслүүд хэрэгжихтэй холбоотойгоор хүн амын шилжин суурьшилт, ажиллах хүчин болон тэдгээрийн гэр бүлийн нийгмийн асуудлуудыг орон нутаг дангаараа шийдвэрлэхэд хүндрэл учирна. Ийм үед компаниудтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлага орон нутгийн удирдлага, иргэдийн дунд үүсдэг.

Харин уул уурхайн компаниудын хувьд орон нутагтай сайн харилцаатай байх нь бизнесийнх нь тогтвортой орших үндэс суурь болохыг улам бүр хүлээн зөвшөөрч байна. Компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт дэмжлэг туслалцаа үзүүлээд зогсохгүй, сайн харилцаа тогтоох, нутгийн удирдлага болон иргэд, тэр дундаа төслийн нөлөөнд автсан

бүлгүүдийн ашиг сонирхлыг хүндэтгэх явдлыг бизнесийн нэг салшгүй хэсэг, соёл гэж авч үзэх болжээ. Нэр хүнд сайтай байх нь тогтвортой бөгөөд ашигтай бизнесийн үндэс суурь болохыг олборлох компаниуд улам бүр ойлгож, орон нутгийн харилцааны асуудалд их хүч, хөрөнгө зарцуулах болсон. Ялангуяа иргэд, орон нутгийнхантай тодорхой асуудлуудаар зөвшилцөлд хүрэх, хэлэлцээнд тэднийг оролцуулах явдал сүүлийн жилүүдэд сайн туршлага болон хэвшиж байна.

Компани, орон нутгийн харилцаа болон уул уурхайн төслийн тухайн орон нутагт үзүүлэх үр нөлөө олон арга зам, хэлбэрээр илэрдэг. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд юуны өмнө хуулиар ногдох татвар, төлбөрүүдийг төрийн холбогдох байгууллагуудад төлнө. Эдгээр татвар төлбөрийг нийгмийн сайн сайхны төлөө тухайлбал боловсрол, эрүүл мэнд зэрэг нийтлэг үйлчилгээнд зориулан үр дүнтэй зарцуулах нь төр засгийн үүрэг юм. Гэхдээ татвар, төлбөрийн дийлэнх хэсэг нь улсын төсөвт төвлөрөх учраас уул уурхайн үйл ажиллагаа явж буй орон нутагт тэр бүр үр шим нь мэдрэгдэхгүй байж мэднэ. Тухайлбал, 2017 онд уул уурхайн компаниуд 2.1 их наяд төгрөг татвар, төлбөрт төлснөөс 5.4 хувь нь л орон нутгийн төсөвт оржээ. 2018 онд компаниуд нийт 2.8 их наяд төгрөг төлсөн гэж тайлагнаснаас 154.7 тэрбум төгрөг буюу 5.5 хувь нь орон нутгийн төсөвт төлөгджээ.² Энэ нь үнийн дүн ихтэй үндсэн татваруудыг улсын төсөвт төвлөрүүлж, цөөн тооны бага дүнтэй татварыг хураах эрхийг орон нутагт үлдээдгийг харуулна. Мөн эдгээр татварын хувь, хэмжээг тогтоох эрх мэдэл орон нутгийн хувьд хязгаарлагдмал байдагтай холбоотой.

² Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2017 болон 2018 оны нэгтгэл тайлан, www.eitimongolia.mn

Нөгөө талаар, уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч компаниуд орон нутгаас худалдан авалт хийх, нутгийн иргэдийг ажлын байраар хангах нь орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулдаг билээ. Харин нутгийн иргэд уул уурхайн чиглэлээр компаниудтай хамтран ажиллахад туршлага, чадавх дутагдаж мэдэх тул сургалт, бойжуулалтын хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх сонирхол талуудад байдаг. Мөн уул уурхайн төслийн үр нөлөө дэд бүтцийн хөгжилтэй холбоотой. Дэд бүтэц тухайлбал зам гүүр, харилцаа холбоо, цахилгааны хангамж сул орон нутагт уул уурхайн томоохон төслүүд хэрэгжсэнээр энэ хүрээнд баригдах дэд бүтцийг орон нутгийнхан мөн ашиглах боломж бүрдэнэ. Нөгөө талаас, орон нутгийн иргэдийн хэрэгцээг хангах зориулалттай дэд бүтцийг компаниуд ашигласнаар хүрэлцээ, чанар доройтох эрсдэл бий.

Эдгээр асуудлыг зохицуулахад чиглэсэн харилцаа компани болон орон нутгийнхны дунд зайлшгүй үүсэх бөгөөд энэхүү гарын авлагын гол сэдэв болсон орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ нь уг харилцааг зохицуулах чухал хэрэгсэл байх боломжтой. Гэхдээ талуудын харилцаа зөвхөн нэг гэрээгээр хязгаарлагдахгүй ба гэрээ нь өргөн хүрээтэй бөгөөд харилцааны зөвхөн нэг хэсэг нь болохыг ойлгох нь чухал юм.

Орон нутгийн гэрээг хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болгонтой байгуулах уу гэсэн асуулт түгээмэл гардаг. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийг харвал, гэрээ байгуулах нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар оногдуулсан заавал биелүүлэх үүрэг бөгөөд үүнд хайгуулын, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хэмээн тусгайлан дурдаагүй нь бүх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нэгэн адил хамаарах үүрэг болохыг илтгэж

байна. Гэхдээ мэдээж гэрээгээр зохицуулах асуудал, компанийн хүлээх үүрэг хариуцлага нь төслийн үйл ажиллагаа, цар хүрээ, үзүүлэх нөлөөлөл, компанийн чадавх зэрэгтэй бодитойгоор уялдсан байх шаардлагатайг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хүлээлгэх үүрэг хариуцлага нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийнхээс ялгаатай байх ёстой.

Энд онцлон дурдах ёстой бас нэг зүйл бол төрийн өмчит уул уурхайн компаниуд бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэгэн адил орон нутагтай гэрээ байгуулж хамтран ажиллах үүрэгтэй юм. Өнөөгийн туршлагаас харахад төрийн өмчит компаниуд гэрээ байгуулах явдал хангалтгүй байгаа тул тэдгээрийг энэхүү үүргээс чөлөөлсөн ямар нэгэн эрх зүйн баримт бичиг одоогоор байхгүй гэдгийг анхаарч, шаардлага тавих нь чухал юм.

ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ



Д.Бямбажав “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний тухай”

<https://www.youtube.com/watch?v=DOJBNbKmX8w>

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг улс орнуудад нийгмийн хариуцлагын, оролцооны, орон нутгийн хөгжлийг дэмжих болон үр өгөөж хуваах гэрээ гэх зэргээр өөр өөрөөр нэрлэдэг ч үндсэн үүрэг нь уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутагт бий болгох нийгэм-эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэдэг. Уул уурхайн компани нь орон нутгаас ажиллах хүчин авах, худалдан авалт хийх, дэд бүтцийг сайжруулах болон хамтран ашиглах, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих, бэлчээр, усны нөөцийг хамгаалах зэргээр тухайн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой. Энэ нь эргээд орон нутгийн ард иргэдийн дэмжлэгийг хүлээх, бизнесийн таатай орчныг бий болгох давуу талтай.


Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний үндсэн чиг үүрэг:

- Уул уурхайн төслийн байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах
- Уул уурхайн төслөөс орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тодорхойлох
- Орон нутагт төслийн талаарх мэдлэг, дэмжлэг бүрдсэн таатай орчныг бий болгох

Энэ харилцааг орон нутгийн гэрээгээр зохицуулах боломжтой юм. Өөрөөр хэлбэл, орон нутгийн гэрээ нь аливаа асуудал тулгарахад харилцан ойлголцох, хамтран ажиллах чухал гүүр болдог.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ нь бэлтгэх, хэлэлцэн тохиролцох, хэрэгжүүлэх гэсэн үндсэн 3 үе шаттай үйл явц юм.

- Уул уурхайн компани ба орон нутгийн холбогдох талуудын хооронд үр дүнтэй харилцах механизм болох



Схем 2. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний үе шат

Эдгээр бүх үе шатанд ил тод байдлыг хангах нь чухал бөгөөд ингэхдээ дараах зүйлсийг анхаарвал зохино. Үүнд:

- Ямар мэдээлэл, баримт бичиг байгаа талаар жагсаалт гаргаж, олон нийтэд хүргэх;
- Холбогдох бүх хурал, хэлэлцээний тэмдэглэл хөтлөх, түүнийг тухай бүрд нь ил болгох;
- Баримт бичгүүдийг бүхэлд нь ил нийтлэх;
- Мэдээллийг хэлэлцэхээс өмнө буюу хэлэлцэх үе шатанд тогтмол ил болгох, мөн ашиглах шаардлагатай үед нь, өөрөөр хэлбэл, хэрэгтэй цаг хугацаанд ил болгох;
- Мэдээллийг аль болох санаачилгаараа, иргэд шаардаагүй байсан ч ил болгох;
- Ил болгох сувгуудаа иргэдэд хүртээмжтэй байхаар бодолцож, олон сувгийг зэрэг ашиглах.



САЙН ТУРШЛАГА: ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд ил тод байдлыг дээд зэргээр хангах нь гэрээг сайн нөхцөлөөр байгуулах, түүнийг амжилттай хэрэгжүүлэх угтвар нөхцөл юм. Ил тод байдлыг хангаснаар иргэд гэрээ байгуулж байгаа талуудын хандлага, байр суурийг ойлгох буюу хянах, мөн өөрсдийн санал бодлыг тухай бүрд нь илэрхийлэх, гэрээ байгуулагдсаны дараа хэрэгжилтэд нь хөндлөнгийн хяналт тавих боломжийг олгоно. Харин иргэдийн дэмжлэг, зөвшөөрлийг аваагүй гэрээ бодитой хэрэгжих боломж бага юм. Гэрээний болон хэлэлцэж буй асуудлын агуулга, нөхцөлийг хэлэлцэн тохирох болон хэрэгжүүлэх үйл явц аль аль нь ил тод байх ёстой. Мөн уг гэрээнд ил болгосноор бизнесийн болон нутгийн засаг захиргааны эрх ашигт сөрөг нөлөө, хохирол учруулах, нууцлах зайлшгүй шаардлагатай зүйл ордоггүй. Харин ч ил тод бус байх нь эсрэгээрээ хардлага сэрдлэг үүсгэх, ашиг сонирхлын зөрчилтэй, хууль бус, орон нутагт ашиггүй, авлигын шинжтэй хэлцэл явагдах хөрс суурийг бүрдүүлж мэднэ. Өөрөөр хэлбэл, ил тод байдлыг хангахын давуу тал болон ил тод бус байхын сөрөг нөлөөлөл хоёр хоршиж, орон нутгийн хамтын ажиллагааг үр дүнгүй болгох эрсдэлтэй.

ГЭРЭЭНИЙ БЭЛТГЭЛИЙН ҮЕ ШАТ



Д.Бямбажав “Бэлтгэлийн үе шатанд анхаарах зүйлс”

<https://www.youtube.com/watch?v=e1U8gxiG5GE>

Энэ үе шатанд орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулахад шаардлагатай дараах бэлтгэлүүдийг хангасан байх нь чухал. Үүнд:

- Тухайн гэрээгээр шийдвэрлэхийг зорьж буй асуудлуудыг ойлгож тодорхойлох;
- Холбогдох төслийн талаар иж бүрэн ойлголт, мэдээлэлтэй болох;
- Төслийн нөлөөллийн бүс, нөлөөлөлд өртөх талуудыг тодорхойлох;
- Гэрээг байгуулах ажлыг хариуцах албан тушаалтан, ажлын хэсгийг зохион байгуулах;
- Цуглуулсан мэдээллээ үр дүнтэй ашиглах, олон нийтэд ил болгох;
- Иргэдийн оролцоог хангах, ялангуяа төслийн нөлөөлөлд өртөх талуудад мэдээлэл өгч, санал шүүмжийг авах Сонсох ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах;
- Гэрээ байгуулахад баримтлах зарчмуудыг тодорхойлох зэрэг ажлыг гүйцэтгэсэн байвал зохино.

ОРОН НУТГИЙН ГЭРЭЭГЭЭР ШИЙДВЭРЛЭХИЙГ ЗОРЬЖ БУЙ АСУУДЛАА ТОДОРХОЙЛОХ

Ашигт малтмалын тухай хуулиар орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосон бөгөөд хамрах хүрээг нь байгаль орчныг хамгаалах, уурхай байгуулахтай холбоотой дэд бүтэц хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зэргээр хязгаарлаж өгсөн байдаг. Гэхдээ хамтын ажиллагааны гэрээ нь зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй олон асуудлыг хамрах боломжтойгоос гадна тухайн орон нутгийн хувьд бүх асуудлыг заавал гэрээгээр зохицуулах шаардлагагүй ч байж болно. Тиймээс орон нутаг гэрээг ямар зорилгоор байгуулахаа эртнээс шийдвэрлэсэн байвал зохино. Тухайлбал, орон нутагт уул уурхайн хэд хэдэн төсөл хэрэгжих тохиолдолд тэдгээртэй байгуулах гэрээнүүд ижил төстэй, эсвэл ялгаатай байх эсэх, хоорондоо ямар уялдаатай байхыг шийдэх шаардлагатай. Эдгээр гэрээгээр орон нутгийн ямар хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар засаг захиргаа, иргэдийн түвшинд тодорхой бөгөөд нэгдсэн ойлголттой болсон байх нь чухал. Иймд энэ үе шатанд дараах зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Тухайн төсөл яагаад хэрэгжих болсон, орон нутагт ямар эерэг болон сөрөг нөлөөлөл үзүүлэх;
- Гэрээ байгуулахад орон нутгийг хэн төлөөлөх;
- Тухайн төслийн үргэлжлэх хугацаа, тооцоолсон нийгэм эдийн засгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилтэй хэрхэн уялдуулах, төслөөс орон нутагтаа чиглүүлж болох боломжуудыг тодорхойлох;

- Төсөлд хамрах газар, газрын хэвлийн баялаг нь орон нутгийнхны хувьд ямар үнэ цэнтэй болохыг ойлгох;
- Төсөл болон түүнийг хэрэгжүүлэгч компанийн талаар бүрэн мэдээлэлтэй болох;
- Тухайн төсөлтэй холбоотойгоор орон нутгийнхны эдлэх эрх, хүлээх үүргийг ойлгох;
- Орон нутгийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, компанид тавих саналуудыг томъёолох зэрэг орно.

Эдгээрийг дор сийрүүлэн авч үзье.

УУЛ УУРХАЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ШАЛТГААН, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДЛЫГ ОЙЛГОХ

Байгалийн баялаг нь олон тооны чухал бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, улс орнуудын эрчим хүчний хэрэгцээг хангах үйлдвэрлэлийн чухал хүчин зүйл тул эрэлт хэрэгцээ өндөртэй байдаг. Түүнчлэн уул уурхайн салбарын эдийн засгийн үр өгөөж өндөр байх тул тухайн төсөл нь зөвхөн тухайн компани, эсвэл орон нутгийн асуудал байгаад зогсохгүй улс орны хөгжилд ч чухал нөлөөтэй байх боломжтой (Уул уурхайн төслийн үе шат бүрийн онцлог, нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөлөөллийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг НҮБХХ-өөс боловсруулсан “Хариуцлагатай уул уурхай” сургалтын гарын авлагаас үзнэ үү <https://www.undp.org/content/dam/mongolia/Publications/UNDP%20TRAINING%20MODULE%20ON%20RESPONSIBLE%20MINING%20IN%20MONGOLIA%20-%20MONGOLIAN.pdf>).

Уул уурхайн төсөл нь хэдэн жилээс хэдэн арван жил, бүр 100 жил үргэлжлэх нь ч бий. Эхлээд хайгуулын ажил, үнэлгээний үе шат (1-10+ жил), дараа нь уурхайн төлөвлөлт, барилга барих үе (2-5 жил), олборлолтын үе (2-100 жил), төгсгөлд нь уурхайг хаах, нөхөн сэргээх, хүлээлгэж өгөх (5-30+ жил) ажил хийгддэг. Үе шат тус бүр нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн олон нөлөөлөл, мөн боломжыг бий болгодог.

Тиймээс орон нутгийн хувьд баялгийг ашиглах ерөнхий нөхцөл байдлыг ойлгож, мөн дараах асуултуудыг хэлэлцэн, нэгдсэн мэдээлэл, ойлголттой болох нь аливаа гэрээ хэлэлцээг амжилттай хийх суурь юм. Үүнд:

- Тухайн газар нутагт байгалийн ямар баялаг байгаа талаар мэдээлэл, таамаг бий юу? Тухайн ашигт малтмал нь бусад газар элбэг байдаг уу? Эсвэл зөвхөн тухайн орон нутагт байдаг уу?
- Хөрөнгө оруулагчид тухайн төслийг хэрэгжүүлэх зөвшөөрлөө авсан уу? Авахдаа орон нутгийнхантай зөвшилцөж, мэдээлэл өгсөн үү?
- Орон нутагт төсөлтэй холбоотой дэд бүтцийн ямар барилга, байгууламж ямар зориулалтаар баригдах вэ? Орон нутгийн хөгжил, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй энэ дэд бүтэц хэр уялдах вэ? Орон нутгийн иргэд уул уурхайн дэд бүтцийг ашиглах боломжтой байх уу?

Эдгээр асуултад хариулт авснаар нутгийн удирдлага болон олон нийт тухайн төслийн хэрэгжих ерөнхий нөхцөл байдлыг ойлгож, орон нутгийн эрх ашиг хэрхэн хөндөгдөж болох талаар төсөөлөлтэй болох юм.

ОРОН НУТГИЙГ ХЭН ТӨЛӨӨЛӨХ, НУТГИЙНХАН ГЭЖ ХЭНИЙГ ОЙЛГОХЫГ ТОДОРХОЙЛОХ

Уул уурхайн төсөл нь төслийн цар хүрээ, эрдэс баялгийн төрөл, ашиглалтын технологи, байгаль цаг уур, дэд бүтцийн нөхцөл зэргээс хамааран газар зүйн хувьд жигд бус байдлаар орон нутгийнханд нөлөөлдөг. Харьцангуй жижиг төслийн нөлөөлөл ганц нэг багийг хамрах бол томоохон төслүүдийнх хэд хэдэн зэргэлдээ сум, бүр аймаг, бүс нутгийг хамарна. Уул уурхайн төслийн тусгай зөвшөөрөл хэд хэдэн сум, аймгийг дамнан олгогдсон байж болно. Мөн тухайн төслийн хувьд олборлолт, боловсруулалт, тээвэрлэлт тус тусдаа сум, аймгуудын газар нутаг дамжин явагдах боломжтой.

Иймд хамтын ажиллагааны гэрээг орон нутгийн засаг захиргаатай байгуулна гэж хуульд заасан хэдий ч тус гэрээнд орон нутаг гэж хэнийг ойлгох, төслийн үр нөлөөг засаг захиргааны болон уламжлалт ямар нэгжийн хүрээнд авч үзэхийг урьдчилан тодорхойлбол зохино. Энэ ажлыг орон нутгийн удирдлагууд зохион байгуулахдаа иргэдийн шууд оролцоог хангах замаар төслийн нөлөөллийн бүс, орон нутгийн зааг хязгаарыг тодорхойлох шаардлагатай. Ингэхдээ тухайн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг харгалзах учиртай. Энэхүү баримт бичиг нь төслийн нөлөөллийн бүс, байгаль орчин, хүн амын эрүүл мэнд, аж байдал, тэр ч байтугай түүх соёлын дурсгалд үзүүлэх эерэг, сөрөг бүх нөлөөллийг тодорхойлж, түүнээс урьдчилсан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тогтоодог чухал баримт бичиг юм.

Орон нутгийнхны хувьд хамтын ажиллагааны гэрээтэй холбоотой хариулт нэхсэн олон асуулт байдгийн нэг нь гэрээг аймаг, сумын аль түвшинд байгуулах тухай асуудал юм. Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан гэрээний загварт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хувьд гэрээг аймаг, нийслэлийн Засаг дарга байгуулна гэснээс өөрөөр гэрээг аль шатанд байгуулах асуудлаар хуулийн нарийвчилсан зохицуулалт байхгүй юм. Үүнээс хамааран гэрээг аль түвшинд байгуулах нь орон нутаг болгонд харилцан адилгүй хэрэгжиж, туршлага сургамж болсоор байна. Тухайлбал Дорноговь, Сүхбаатар, Төв аймгуудад гэрээг аймгийн түвшинд байгуулах бодлого барьж байгаа бол Хэнтий, Булган, Завхан аймгууд ихэвчлэн сумын түвшинд, харин Өмнөговь, Ховд аймгуудад аймаг болон төслийн нөлөөлөлд өртөх сумдыг оролцуулсан олон талт гэрээ байгуулсан туршлага байна. Тэр ч байтугай компаниуд багийн түвшинд, эсхүл бүр суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулсан онцлог туршлага байгаа нь Завхан аймгийн Дөрвөлжин сумын Цогт багийн Баян Айраг Эксплорэншн компанитай байгуулсан гэрээ ба Төв аймгийн Заамар сум, Дундговь аймгийн Өлзийт суманд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын төрийн бус байгууллагуутай байгуулсан гэрээ юм. Иймд энэ бүх туршлагын давуу болон сул талыг нарийвчлан үнэлж, эрх зүйн оновчтой зохицуулалт хийх нь чухал юм. Харин газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд сумын захиргаатай гэрээ байгуулж ажиллах талаар Газрын тосны тухай хуульд тодорхой заасан байдаг.

Харин компаниуд аль болох төсөл хэрэгжүүлж байгаа сумтай гэрээ байгуулах сонирхолтой байдаг. Учир нь төслийн нөлөөлөлд өртөх сум орон нутгийн иргэдтэй сайн харилцаатай байх нь үйл ажиллагаагаа тогтвортой явуулах гол нөхцөл болдог.

Хүснэгт 1. Гэрээ байгуулах түвшин: Давуу ба сул тал

Гэрээ байгуулсан түвшин	Давуу тал	Сул тал/анхаарах асуудлууд
Аймгийн түвшинд	<ul style="list-style-type: none"> - Гэрээний ойлголт, чадавх харьцангуй сайн. - Хандив дэмжлэгийг нэг дор төвлөрүүлэн тогтвортой хөгжилд чиглэсэн томоохон хөрөнгө оруулалт хийх боломжтой болно. - Үр өгөөжийг уул уурхайгүй сумдад хуваарилах боломж нээгдэнэ. 	<ul style="list-style-type: none"> - Том төслүүдэд илүү анхаарч, жижиг компаниудтай гэрээ байгуулахгүй орхих. - Төслийн нөлөөлөлд өртөж буй сум, ялангуяа иргэдийн эрх ашгийг орхигдуулах. - Нутгийн иргэдтэй сайн харилцаатай байх компанийн эрх ашиг хангагдахгүй байх. - Аймагтай гэрээ байгуулсан гэсэн шалтгаанаар компани суманд мэдээлэл өгөхгүй, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд сум хяналт тавих боломж буурах. - Байгаль орчны гэх мэт үүргийн хэрэгжилтийг бүрэн хянах боломжгүй.

Сумын түвшинд	<ul style="list-style-type: none"> - Бүх компанийг хамран гэрээ байгуулах боломжтой. - Төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн өмнө компанийн хүлээх хариуцлага нэмэгдэнэ. - Нутгийн иргэдтэй сайн харилцаатай байх компанийн эрх ашиг хангагдана. 	<ul style="list-style-type: none"> - Гэрээний талаарх ойлголт, чадавх харьцангуй сул. - Урт хугацааны хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт хийхгүй байх. - Үр өгөөжийг уул уурхайгүй сумдад хуваарилах боломжгүй.
Аймаг, сум хамтарсан	<ul style="list-style-type: none"> - Хандив дэмжлэгийг нэг дор төвлөрүүлэн тогтвортой хөгжилд чиглэсэн томоохон хөрөнгө оруулалт хийх боломжтой. - Үр өгөөжийг бүх сумдад оновчтой хуваарилах, ингэхдээ төслийн нөлөөлөлд өртөх хүмүүсийн эрх ашгийг харгалзах боломжтой. - Нутгийн иргэдтэй сайн харилцаатай байх компанийн эрх ашиг хангагдах. - Хууль болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих боломж нэмэгдэнэ. 	<ul style="list-style-type: none"> - Богино хугацаатай жижиг төсөл хэрэгжүүлэгч компаниудын ачаа нэмэгдэх магадлалтай тул сумын хэмжээнд аль компанитай гэрээ байгуулж болох талаар аймаг сум хоёр зөвшилцөлд хүрч болох юм. - Сонсох ажиллагааг сум, багийн түвшинд зохих ёсоор хийх замаар төслийн сөрөг нөлөөлөлд өртөх иргэдийн эрх ашгийг хамгаалахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

Төслийн үйл ажиллагаа явагдах болон нөлөөлөлд өртөх бүс нутгийг тодорхойлсны дараа орон нутгийн иргэд гэж хэн байх талаар нэгдсэн ойлголттой болох хэрэгтэй. Тухайн засаг захиргааны нэгж, бүс нутагт амьдарч буй иргэд энэ тодорхойлолтод хамрагдах учиртай. Түүнчлэн уул уурхайн төсөлтэй холбоотойгоор шилжин ирэх иргэд төрийн үйлчилгээ авч, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх нь баталгаажих ёстой. Уул уурхайн нөлөө нийгмийн янз

бүрийн бүлгүүдэд тэгш бус хүрдэг тул эмэгтэйчүүд, хүүхдүүд, мөн цөөнх болон дэмжлэг шаардах тодорхой бүлгүүдийг тусгайлан анхаарч үзэх нь зөв. Улмаар эдгээр бүлгийн төлөөллийг гэрээний бүхий л үйл явцад оролцуулахыг зорьж ажиллахаас гадна тэдний эрх ашгийг мэддэг, хамгаалж чадах төлөөллийг гэрээ байгуулах, хянах ажлын хэсгүүдэд оруулах шаардлагатай. Эдгээр үйл явц нь нутгийнхны нэгдмэл байдлыг сайжруулж, гэрээ хийхэд эерэг нөлөө үзүүлэх болно.



САЙН ТУРШЛАГА: Олон талт гэрээ

Оюу толгойн Хамтын ажиллагааны гэрээ нь Өмнөговь аймаг, Ханбогд болон төслийн нөлөөллийн өөр гурван сум, Оюу Толгой компанийн хооронд байгуулагдсан олон талт гэрээ юм. Өөрөөр хэлбэл, аймаг, сумдын эрх ашиг зарим тохиолдолд өөр байх боломжтойг харгалзан үзэж, аймгийн болон сумдын засаг захиргаа бие даасан тал болж гэрээнд оролцсон. Ийм гэрээний ажлын хэсэгт аймаг, сумдын тодорхой албан тушаалтан болон иргэдийн төлөөлөл оролцсон байвал зохино. Түүнчлэн энэ гэрээнд орон нутгийн малчдын эрх ашиг, санал хүсэлтийг илэрхийлэх зорилготой тусгай дэд хороодыг байгуулахаар заажээ.

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Компаниуд аливаа гэрээг байгуулахад мэргэшсэн хуульч, холбогдох хүмүүсийг ажиллуулдаг. Харин орон нутгийн зүгээс гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох ажлыг гол төлөв төрийн албан хаагчдад үндсэн ажил дээр нь нэмж даалгадаг бөгөөд тэд ийм төрлийн гэрээ байгуулах туршлага тэр бүр эзэмшээгүй байж болно. Тиймээс гэрээг хэлэлцэх, байгуулах үйл ажиллагааг тодорхой удирдамжаар хангаж, ажлын хэсэг буюу багийг зөв зохион байгуулах нь нэн чухал юм. Үүнд дараах асуудлуудыг онцгойлон анхаарах шаардлагатай.

Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангах:

Аймаг, сумдын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга гэрээ байгуулах ажлын хэсгийг ахалж ажиллах нь дараах давуу талтай. Үүнд:

- Холбогдох хэлтэс, байгууллагын ажлын уялдааг хангах;
- Шаардлагатай мэдээллийг шуурхай авах;
- Сум, багийн хэмжээнд уулзалт, хэлэлцүүлэг хийх бэлтгэл хангуулах;
- Ажлын хэсэгт шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэх;
- Аж ахуйн нэгжийн захирал, удирдах албан тушаалтантай эн тэнцүү харилцах.

Ажлын хэсгийн ахлагч болон гишүүд компанитай аливаа байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй байх нь онцгой чухал. Тухайлбал, компаниас шууд болон шууд бусаар ямар нэгэн ашиг, гэрээ аваагүй бөгөөд авахгүй байх, уул уурхайн салбарт бизнес эзэмшдэггүй, өөр ямар

байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй байж сая сайн гэрээ байгуулж чадна гэх олон нийтийн итгэлийг хүлээнэ.

Ажлын хэсгийг үр дүнтэй байгуулах:

- Гэрээ байгуулагдах хүртэлх үйл явцыг хариуцан ажиллах нарийн бичгийн даргатай байх;
- Ажлын хэсгийг гүйцэтгэх ажлын даалгавар, тодорхой удирдамжаар хангах;
- Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд санхүү, байгаль орчин, хөгжлийн бодлогын хэлтэс зэрэг холбогдох нэгжүүдийн удирдлага, төлөөллийг оруулах;
- Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нөлөөллийн бүсийн удирдлага, иргэдийн төлөөлөл орсон байх;
- Иргэдийн төлөөллийг сонгохдоо дараах эх сурвалж, аргуудыг ашиглаж болно. Үүнд:
 - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан, нөлөөллийн бүсийн иргэдтэй хийсэн хэлэлцүүлэг;
 - Багийн иргэдийн нийтийн хурлаас сонгогдсон төлөөлөл;
 - Орон нутгийн иргэдийн үүсгэл санаачилгын төрийн бус байгууллагын төлөөлөл;
- Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардлагатай төсөв хөрөнгийг баталсан байх;

- Ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар олон нийтэд тогтмол мэдээлэх төлөвлөгөө гаргах, үүнд мэдээлэл өгөх арга, хэлбэр, хугацаа, давтамж зэргийг тодорхойлох;
- Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хэн яаж үнэлгээ өгөх, хяналт тавихыг тодорхойлох;
- Иргэдийн төлөөллийг мэдээллээр хангах, чадавхжуулах.

Мэргэжилтнүүдээс туслалцаа авах:

- Уул уурхай, байгаль орчин, санхүү, хуулийн мэргэшсэн зөвлөхөөс туслалцаа авах;
- Хөндлөнгийн мэргэжилтнүүдээс туслалцаа авахад шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэх;
- Орон нутгийн холбогдох хэлтэс, нэгжүүдийн мэргэжилтнийг сургах, туршлага судлуулах;
- Шаардлагатай тохиолдолд 2-3 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжилтний багийг татан оролцуулах.

Мэргэжилтнүүдээс туслалцаа авах нь чухал байж болох ч орон нутгийн удирдлага болон ажлын хэсэгт орсон албан тушаалтан, мэргэжилтэн, иргэд холбогдох хууль тогтоомж, орон нутгийн хамтын ажиллагааны загвар гэрээ, бусад гэрээг гэрээний цахим сан (www.iltodgereee.mn) болон бусад эх үүсвэрээс авч танилцах замаар бусад орон нутгийн туршлагыг судлах хэрэгтэй.



САЙН ТУРШЛАГА: Хараат бус мэргэжилтнүүдийн туслалцаа

Австрали Улсад Вэйпагийн хөнгөн цагааны хүдрийн уурхайг ашиглах үед орон нутгийн удирдлагаас Хамтын ажиллагааны гэрээ байгуулах 3 хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцээ хийх ажлын хэсгийг томилжээ. Ингэхдээ Австралийн Гриффитийн их сургуулийн профессор багшийг ажлын хэсэгт оруулжээ. Ажлын хэсгийн зөвлөхөөр хараат бус шинжээчдийг ийнхүү ажиллуулах нь Австрали, Канад улсуудад түгээмэл байдаг.

Олон нийт, талуудын оролцоог хангах:

- Ажлын хэсгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх дотоод дүрмээ тодорхойлох;
- Төслийн нөлөөллийн бүсийн иргэдтэй үр дүнтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг ажлын хэсэгт гишүүн эсвэл ажиглагчаар оролцуулах;
- Холбогдох зардлыг тооцож тусгах.

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦАД ХЯНАЛТ ТАВИХ

2016 онд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээний загвар”-ын 4.1-д дараах хяналтын механизмыг тусгасан байна. Үүнд:

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын оролцоо, дэмжлэг, хяналтыг бий болгох:

- Ажлын хэсгийн гэрээг байгуулахад баримтлах үндсэн чиглэл, агуулгын хүрээг хэлэлцүүлэх, санал, дүгнэлт авах;
- Ажлын хэсгийн ажлын явцын танилцуулга хийх;
- Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох төлөөллийг оролцуулах;

- Нээлттэй сонголт, сонсох ажиллагааг хамтран зохион байгуулах;
- Төслийн нөлөөллийн бүсийн уулзалт, хэлэлцүүлэгт төлөөлөгчдийн оролцоог хангах.



САЙН ТУРШЛАГА: ИТХ-ын оролцоо

2015 онд Ховд аймгийг төлөөлөх ажлын хэсэг нь МоЭнКо компанитай байгуулах хамтын ажиллагааны гэрээний үндсэн нөхцөл, хүрээг тодорхойлж, түүнийгээ аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, хэлэлцээ хийх зөвшөөрөл авчээ. ИТХ-аар хэлэлцүүлэх нь ажлын хэсэгт гэрээний үндсэн нөхцөл, хэлэлцээнд анхаарах асуудлуудын талаар үнэтэй санал, зөвлөмж болон гэрээг байгуулахад шаардлагатай улс төрийн ба захиргааны дэмжлэг авах, мөн гэрээнд нөлөөллийн бүсийн эрх ашгийг орхигдуулахгүй байх, гэрээний талаарх мэдээллийн ил тод

байдлыг сайжруулах давуу тал бий болгосон.

МЭДЭЭЛЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАХ

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулахад шаардлагатай мэдээллийг талууд эмх цэгцтэй, иж бүрэн цуглуулахыг зорих хэрэгтэй. Цуглуулсан мэдээлэл нь тухайн төслийн зорилго болон ерөнхий нөхцөл байдал, мөн орон нутагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг орон нутгийн удирдлага, иргэд бүрэн дүүрэн ойлгоход туслах учиртай. Түүнчлэн орон нутгийн удирдлага, иргэд болон компанийн эрх үүрэг юу байх талаар талууд мэдээлэлтэй байх нь хэлэлцээ хийхэд тустай.

Хүснэгт 2. Төслийн талаарх мэдээллийг авах, хэрэгцээг тодорхойлох

Мэдээллийн төрөл	Мэдээлэл авч болох эх сурвалж	Мэдээллийг ашиглах болон дутуу мэдээллийг нөхөх
Төслийн талаарх мэдээлэл		
Төслийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Компани, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	Төслийн ашиг, орон нутагт үзүүлэх эдийн засгийн үр нөлөөг ойлгоход тустай. Гэхдээ эдгээр үзүүлэлт нь ирээдүйн талаарх төсөөлөл байдаг тул учрах эрсдэлийн талаар нэмэлт мэдээлэл авах шаардлага үүснэ.
Байгаль орчны нөлөөлөл	Компани, Байгаль орчны яам https://eic.mn/eia/ , Орон нутгийн удирдлага	Төслийн байгаль орчны эрсдэлийг ойлгох.

Байгаль орчны ажлын төлөвлөгөө, барьцаа, хаалтын төлөвлөгөө	Компани, Байгаль орчны яам https://eic.mn/eia/ , Орон нутгийн удирдлага	Төслийн байгаль орчны эрсдэлийг шийдэх төлөвлөгөө байгаа эсэх, хэр бодитой болохыг ойлгох.
Төслийн эдийн засгийн ашиг	Компани, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	Орон нутагт үзүүлэх дэмжлэгийн талаар бодитой ойлголттой болох.
Ашиглалтын технологи ба ижил төстэй төслүүд	Компани, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	Уурхайн үйл ажиллагааг илүү нарийвчлан ойлгох, мөн ашиглалтын технологиос үүдэлтэй байгаль орчны эрсдэлийг тооцож, төлөвлөх.
Төслийн хөрөнгө оруулалт, зардал, ашиг, гарч болох эрсдэл	Компани, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	Тухайн төслийн орон нутагт үзүүлэх нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөлөөг нарийвчлан судалж, төслийн талаарх хүлээлтийг оновчтой тодорхойлох.
Төслийг хэрэгжүүлэх дэд бүтэц	Компани, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	Тухайн төсөлтэй холбоотой дэд бүтцийн өгөөжийг судлах, орон нутагт үзүүлэх нөлөөг тооцох.
Төслийн үйл ажиллагаатай холбоотой аюулгүй ажиллагааны эрсдэл	Компани	Учир болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, мөн уурхайн нөлөөллийн бүсийн иргэдэд мэдээлэл хуваалцах.
Ажиллах хүчний хэрэгцээний талаарх мэдээлэл	Компани	Орон нутгаас ажиллах хүч, мэргэжилтэн авах боломж, орон нутгийн ажиллах хүчний нөөц бололцоог тодорхойлох.

Ажиллах хүчний чадвар, мэргэжлийн чиглэл	Компани	Орон нутгаас авч ажиллуулах ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх боломжийг тодорхойлох.
Компанийн худалдан авалтын тооцоолол	Компани	Хоол хүнс, тээвэр зэрэг худалдан авалтыг орон нутгийн хүрээнд хийх боломжийг тодорхойлсноор орон нутгаас худалдан авч болох бараа, үйлчилгээний жагсаалт гаргах, дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх ажлыг гэрээнд тусгуулах.
Компанийн талаарх мэдээлэл		
Компанийн эзэмшил, санхүүжилт, тайлан	Компани, Татварын Ерөнхий Газар, Улсын Бүртгэлийн Ерөнхий газар - opendata.burtgel.gov.mn/ , ОУИТБС - http://e-reporting.eitimongolia.mn , Монголын хөрөнгийн бирж - mse.mn	Тухайн компанийн эцсийн өмчлөгч эзэд нь улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тодорхойлж болно. Санхүү, татвартай холбоотой мэдээллийг бүрэн судалж үзэх боломжтой.
Компанийн зорилго, үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоо	Компани	Тогтвортой үйл ажиллагаа явуулж, хариуцлагатай уул уурхайг дэмжиж ажиллах эсэх.
Компанийн өмнөх туршлага, нийгмийн хариуцлагын түүх	Компани	Өмнө нь хариуцлагатай ажиллаж байсан эсэх, орон нутагт дэмжлэг үзүүлэн ажиллах эсэх, эрсдэл, зөрчил гарсан тохиолдолд компанид хэрхэн хэрхэн хандаж, шийдвэрлүүлэхийг мэдэх.

Хууль эрх зүйн мэдээлэл	Эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn	Холбогдох хууль тогтоомжоор компанийн хүлээсэн үүрэг, хариуцлага, орон нутаг, иргэдийн эдлэх эрх, хүлээх үүргийг зөв ойлгож, ашиглах.
Монгол Улсын стандарт	Эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам - www.mmhi.gov.mn , АМГТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Төсөлтэй холбоотой стандарт, журмыг дэлгэрэнгүй судлах.
Үндэсний ба олон улсын туршлага, сургамж		
Олон улсын холбогдох стандарт	ISO стандарт, ОУИТБС-ын стандарт www.eitimongolia.mn	Олон улсын стандартуудыг судалж, төслийн үйл ажиллагаанд холбогдох стандартуудад нийцэж байгаа эсэхийг судлах.
Судалгаа, мониторингийн тайлан	Нээлттэй Нийгэм Форум болон бусад	Уул уурхай, байгаль орчны чиглэлээр хийсэн судалгаа, мониторингийн тайлан судлах.
Ижил төстэй төслийн талаарх мэдээлэл	Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан - www.iltodger-ee.mn ОУИТБС - https://eiti.org/explore-data-portal Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн - https://resourceprojects.org	Үндэсний хэмжээнд байгуулсан орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, зарим улс орны ижил төстэй төсөл, тэдгээрийн үр ашгийн талаар судлах.



НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ: Уул уурхайн төслийн орон нутгийн эдийн засгийн нөлөөг үнэлэх

Эдийн засгийн нөлөөг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг авч үзэж болно. Үүнд:

1. Засгийн газар ба орон нутагт төлөх татвар, хураамж ба түүний хуваарилалт;
2. Орон нутагт шууд ба шууд бусаар нэмэгдэх ажлын байрны тоо;
3. Орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс нийлүүлэх боломжтой бараа, ажил үйлчилгээний нийт дүн;
4. Орон нутгийн дэд бүтцийн хөгжилд оруулах шууд ба шууд бус хувь нэмэр.

Гэхдээ уул уурхайн төсөл хэрэгжих нь орон нутгийн ажиллах хүчин, нөөц боломжийг татах тул уламжлалт мал аж ахуй, газар тариалан зэрэг бусад салбарт ямар нөлөө үзүүлэхийг анхааралтай тооцох шаардлагатай. Ажилгүйдэл их, бизнесийн нөөц боломж тухайн орон нутгийнхны хувьд хязгаарлагдмал бол уул уурхайн төслийн эерэг нөлөө давамгайлах боломжтой байсан ч үр шим ихтэй газар тариалангийн, эсвэл тогтсон бэлчээрийн нутгийг төслийн хэрэгцээнд авах нь энэ чиглэлийн бизнес эрхлэгчдэд хүндээр тусна. Тиймээс эдгээр салбарын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Бие даан судлах эх сурвалж: Англо Американ компани “Нийгэм эдийн засгийн үнэлгээний аргачлал” 3 дахь хувилбар. 2015 он. Монгол хэлээр. www.angloamerican.com/~media/Files/A/Anglo-American-PLC-V2/documents/communities/feb-2015-seat-mongolian.pdf

Хүснэгт 3. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн суурь мэдээллийг бэлтгэх

Төслийн нөлөөллийн бүсийн талаарх мэдээлэл	Боломжит эх сурвалж	Зөрүү
Төслийн нөлөөллийн бүсийн хүн амын үндсэн үзүүлэлт		
Төслийн нөлөөллийн бүсийн хүн амын амьжиргаа	Үндэсний статистикийн хороо - https://www.1212.mn/sonirkholtoi/	
Төслийн нөлөөллийн бүсийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж		
Төслийн нөлөөллийн бүсийн байгаль орчны төлөв байдал	Байгаль орчны мэдээллийн сан - www.eic.mn	
Төслийн нөлөөллийн бүс дэх соёлын өв	Улсын болон аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал http://culture.gov.mn/p/r0?id=6	
Төслийн нөлөөллийн бүс дэх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа	Орон нутгийн татварын алба, хөгжлийн бодлого хариуцсан нэгж	
Аймаг, сумын санхүү, хөрөнгө оруулалтын мэдээлэл, төлөвлөгөө, хэрэгцээ	Боломжит эх сурвалж	Зөрүү
Төсвийн орлого, зарлага	Сангийн яам - www.mof.gov.mn , www.iltod.gov.mn	
ОНХС-ийн орлого, зарцуулалт	Сангийн яам, ОНХС-ийн мэдээлэл - www.tusuv-oronnutag.mof.gov.mn	
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиглэлүүд	Үндэсний хөгжлийн газар - www.nda.gov.mn	
Тэргүүлэх салбарууд		

Мэдээллийн хадгалалт, ашиглалтыг төлөвлөх

- Мэдээллийг цахим ба хэвлэмэл байдлаар хадгалах, холбогдох журмын дагуу архивлах;
- Ажлын хэсгийн хэрэгцээний мэдээллийн сан үүсгэх, ашиглах горимтой байх;
- Гэрээ байгуулах үйл явцын мэдээлэл буюу уулзалтын тэмдэглэл, иргэдийн санал хүсэлт зэргийг мэдээллийн санд оруулах;
- Хэрэгцээтэй мэдээллийн жагсаалт үүсгэх, мэдээллийн бүрэн байдал, шинэчилсэн эсэхийг тэмдэглэх;
- Мэдээллийг олон нийтэд ил болгох.

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ

Орон нутгийн хөгжилтэй холбоотой аливаа асуудлаар нутгийн бүх иргэдийн оролцоотойгоор шийдвэр гаргах ёстой. Зөвхөн нутгийн удирдлага, эсвэл цөөн нөлөө бүхий манлайлагчдын хүрээнд олон нийтийн эрх ашигт нөлөөлөх шийдвэрийг гаргах нь зохимжгүй. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ нь нутгийн иргэдийн эрх ашигт их нөлөөтэй байж, нутгийн хөгжлийн асуудлуудыг хөндөх тул шийдвэр гаргах явцад оролцох боломжийг бүх иргэнд гарган өгч, тодорхой арга замаар нутгийнхныг чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэлтэй болгосны дараа зөвшөөрөл авахыг зорих хэрэгтэй. Нөгөө талаар, Захиргааны ерөнхий хуулийн дагуу орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ нь захиргааны шийдвэр тул тухайн шийдвэрийн улмаас эрх ашиг нь хөндөгдөх талуудтай урьдчилан зөвшилцөх хуулийн шаардлага үүсэх юм.



НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ: Сайн дурын үндсэн дээр мэдээлэлд суурилан чөлөөтэйгөөр, урьдчилж өгсөн зөвшөөрөл

НҮБ-аас нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалах үүднээс тэднийг амьдарч буй газар нутгаас нь нүүлгэхэд албадлагаас ангид буюу мэдээлэл авсны үндсэн дээр өөрсдөө чөлөөтэйгөөр шийдэж өгсөн зөвшөөрлийг нь заавал урьдчилан авч байх явдлыг тунхагласан байдаг. Байгалийн баялаг ашиглах төслүүдийг санхүүжүүлэгч олон улсын байгууллагууд, тухайлбал Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, мөн зарим компаниуд нутгийн иргэдтэй тодорхой төслийн хүрээнд харилцахдаа энэ зарчмыг хангаж, зөвшөөрлийг нь авахыг эрмэлзэх буюу шаардах болсон.

Энэ зарчмын хувьд тухайн төслийг батлах, түүнийг хэрэгжүүлэхэд нутгийн иргэдтэй зөвшилцөөд зогсохгүй төсөл хэрэгжүүлэх шийдвэр гарахаас өмнө дэлгэрэнгүй бөгөөд үнэн зөв мэдээллийг уугуул иргэдийн онцлогт тохирсон хэлбэр, арга замаар урьдчилан өгөх, саналаа бэлтгэх зохистой хугацаа олгох, ямар нэг дарамт шахалтгүйгээр өөрсдөө чөлөөтэй шийдвэр гаргах боломж олгохыг шаарддаг. Өөрөөр хэлбэл. “чөлөөтэй ” гэдэг нь нутгийн иргэдийг ямар нэгэн байдлаар айлган сүрдүүлэхгүй, удирдан залахгүй байх, “урьдчилж” гэдэг нь тэдэнд шийдвэр гарахаас өмнө шаардлагатай хугацаа өгч, хэлэлцэх боломж олгох, “мэдээлэлтэй” гэдэг нь тухайн компанийн төлөвлөгөө, төслийн цар хүрээ, зорилго, үр нөлөө, эрсдэлүүдийн талаар бүрэн мэдээлэл өгөхийг илтгэх бол “зөвшөөрөл” гэдэг нь тэдэнд “үгүй” гэж хэлэх эрхийг нь үлдээхийг ойлгоно.

Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад анхаарах зүйлс:

- Хэлэлцүүлгийн зорилго тодорхой байх (санал шүүмж цуглуулах, асуудлын шийдлийг тодорхойлох, мэдээлэл танилцуулах, нэгдсэн ойлголтод хүрэх);
- Хэлэлцүүлгээр төслийн талаарх албан ёсны, нягталсан мэдээлэл хүргэх;
- Хэлэлцэх асуудлын талаар аль болох шуурхай, уншиж ойлгоход хялбар мэдээлэл өгч, иргэдэд байр сууриа тодорхойлох хангалттай хугацаа олгох;
- Хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа мэдээлэл солилцох олон сувгуудыг ашиглах;
- Аж ахуйн нэгжтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулах эсвэл орон нутгийн захиргаа дангаар зохион байгуулахын давуу ба сул талыг бодолцож, эдгээрийг дангаар болон хослуулан зохион байгуулах;
- Хэлэлцүүлэгт өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, ажилгүй иргэд зэрэг нийгмийн эмзэг хэсгийнхний оролцоог хангах, шаардлагатай тохиолдолд хэсэгчилсэн, ганцаарчилсан уулзалт ярилцлага хийх;
- Эмэгтэйчүүдийн оролцоог хангахад анхаарч хэлэлцүүлэг зохион байгуулах газар, цагийг уялдуулах.

Сонсох ажиллагаа зохион байгуулах:

- Захиргааны ерөнхий хуулиар захиргааны байгууллага нь шийдвэрээ (захиргааны акт, захиргааны гэрээ) батлан гаргахын өмнө иргэн, хуулийн этгээдэд санал, тайлбар гаргах боломж олгох ёстой. Энэ нь юуны өмнө тухайн шийдвэрийг гаргаснаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийн хүрээг тодорхойлж, тэдэнд заавал урьдчилан мэдэгдсэнээр санал, тайлбараа (бичгээр эсвэл амаар) гаргах бололцоог бүрдүүлдэг. Ингэхдээ тухайн шийдвэр, түүнийг гаргахад харгалзан үзэх нөхцөл байдлын талаарх бүрэн дүүрэн мэдээллийг урьдчилж заавал өгөх ёстой.
- Сонсох ажиллагааг утсаар, цахимаар, бичгээр, ганцаарчилсан болон олон хүнийг хамарсан уулзалт хэлэлцүүлэг зэрэг аль тохиромжтой хэлбэрээр сонгон зохион байгуулж болно.
- Сонсох ажиллагаанд оролцох талуудыг хэрхэн тодорхойлсон, хэнд ямар аргаар хэзээ, ямар мэдээлэл өгсөн, сонсох ажиллагааг хаана, хэрхэн зохион байгуулсан, хэн оролцож, ямар санал гаргасан, саналыг тухайн шийдвэрт хэрхэн тусгасан, эсхүл яагаад тусгаагүй болон гарсан шийдвэр, түүнд өөрийнх нь гаргасан саналыг хэрхэн тусгасан талаар оролцогчдод хэзээ хэрхэн мэдээлсэн гэх мэт асуудлыг тусгасан тэмдэглэл хөтлөх шаардлагатай. Уг тэмдэглэлд сонсох ажиллагааг зохион байгуулахад захиргааны ямар албан тушаалтан, ямар үүрэг рольтой оролцсоныг мөн тусгах ба энэ нь тухайн албан тушаалтны ажил үүргийг үнэлэхэд харгалзан үзэх нөхцөл болно.

- Захиргааны байгууллага сонсох ажиллагаа хийхгүй байх нь өөрийн үзэмжээр шийдэх асуудал биш бөгөөд хэрэв хийхгүй гэвэл Захиргааны ерөнхий хуульд заасан гарцаагүй нөхцөл байдал бий болсон гэдгийг захиргааны байгууллага нотлох үүрэгтэй. Ийнхүү нотолж чадахгүй бол тухайн шийдвэрийг эрх зүйн зөрчилтэй гэж үзэн гомдол гаргах, улмаар уг шийдвэрийг гаргасан албан тушаалтанд захиргааны хариуцлага тооцох үндэслэл болно.
- Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд гэдэг нь тухайн шийдвэр (захиргааны акт, захиргааны гэрээ) гаргасны улмаас эрх, ашиг сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөж буй иргэн, хуулийн этгээд юм.

СОНГОХ АЖИЛЛАГАА

Оролцогчийг сонгох

Захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий л нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах этгээд

Сонгох ажиллагаа явуулах

Захиргааны шийдвэр гаргах захиргааны байгууллага эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлно.

Мэдэгдэх хүргүүлэх

20 буюу түүнээс доош тооны этгээдийг сонгохоор бол мэдэгдлийг этгээд тус бүрд шууд хүргүүлэх.

21 буюу түүнээс дээш тооны этгээдийг сонгохоор бол төлөөлөгчид шууд хүргүүлэх эсвэл бусад арга хэрэгслийг ашиглан хүргүүлэх.

Мэдэгдэл дараах мэдээллийг тусгана

сонгох ажиллагаа явуулах журам

дарааллын талаарх мэдээлэл

ажиллагаа явуулах он, сар, өдөр, цаг, байрлал

холбогдох хуулийн зүйл заалт

тухайн асуудлын талаарх мэдээлэл, үндэслэл

Сонгох ажиллагааг дараах арга хэлбэрээр явуулна

сонсгол

бичгээр

уулзалт

утсаар

цахим хэлбэрээр

бусад

Тэмдэглэл хөтлөх

Сонгох ажиллагааны явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны шийдвэрт хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж баримтжуулна

Саналыг захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд заавал тусгах үүрэг хүлээхгүй боловч тусгаагүй шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.

Схем 3. Захиргааны ерөнхий хууль дахь Сонгох ажиллагааны зохицуулалт

Олон нийтэд мэдээлэл өгөх:

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, хянах бүхий л үйл явц олон нийтэд ил тод явагдах ёстой. Ийм төрлийн гэрээнд нууцалбал зохих төрийн болон бизнесийн ямар нэгэн мэдээлэл агуулагддаггүй бөгөөд мэдээлэл авах, өөрсдийн эрх ашигт хамаатай шийдвэрт нөлөөлөх олон улсын болон дотоодын хууль эрх зүйн хүрээнд тодорхойлогдсон иргэдийн эрх баталгаажих нь тэргүүн ач холбогдолтой. Иргэдэд мэдээлэл өгөх нь тухайн төсөлтэй холбоотой үүсэх хүлээлтийг бодитой байлгаж, улмаар ирээдүйд үүсэж болзошгүй үл ойлголцлоос сэргийлэх, иргэдийн гэрээ байгуулах болон түүний хэрэгжилтэд хяналт тавихад оролцох боломжийг тайлбарлах зорилгыг агуулах юм.

Хүснэгт 4. Мэдээллийг ямар сувгаар, ямар хэлбэрээр өгөх нь хамгийн үр дүнтэй болохыг тодорхойлох

Мэдээлэл өгөх арга, хэлбэр	Аймгийн/сумын нийт иргэд	Нөлөөллийн бүсийн иргэдэд
Сошиал медиа	+	+
ТВ, радио	+	+
Орон нутгийн мэдээллийн самбар	+	
Утас, мессеж	+	+
Баг, хороо, хэсгийн ажилтнууд	+	+
Байгууллагын цахим хуудас	+	
Сонин	+	
Гар утасны аппликэшн	+	+
Бусад		

- Мэдээллийг уншаад нэмэлт мэдээлэл авах, хариу санал, хүсэлт илгээх боломжоор хангах. Гэхдээ иргэд тэр бүр хариу санал хүсэлт илгээхгүй, асуулт асуухгүй байж болох ба энэ нь мэдээлэл өгөхгүй байх үндэслэл болохгүйг анхаарах хэрэгтэй. Мөн эмзэг асуудлаар иргэд асуулт асуух, саналаа илгээхдээ нэр усаа нууцлах боломж олгох нь чухал.



НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ: Ил тод байдлыг хангах талаарх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.10-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд

мэдээлэх үүрэгтэй.

Энэхүү үүргийн хүрээнд компанийн тухайн төслөөсөө орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хандив дэмжлэгийн мэдээллийг нийтэд мэдээлэхийг орон нутгийн иргэд шаардаж болох юм. Тэрчлэн татварын мэдээллээс гадна түүний бүртгэлийн дугаар, холбоо барих хаяг, өмчлөгч, тусгай зөвшөөрлийн мэдээлэл, эвдрэлд орсон газар, нөхөн сэргээлт, түүний зардал зэрэг маш олон төрлийн мэдээллийг ОУИТБС-ын хүрээнд (<http://e-reporting.eitimongolia.mn/>) компанийн гаргасан жил бүрийн тайлангаас олж авч болно.

Байгууллагын нууцын тухай хуулиар байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй үйл ажиллагаа, химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаарх мэдээллийг нууцлахыг хориглосон байдгийг мэдэхэд илүүдэхгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧМУУДАА ТОДОРХОЙЛОХ

Ажлын хэсэг орон нутгийн гэрээг байгуулахад баримтлах үндсэн зарчим, гэрээнд тусгах агуулгын хүрээ, гэрээ байгуулснаар гарах үр дүнгийн талаарх стратегийн баримт бичиг боловсруулах нь ач холбогдолтой. Үүнд дараах зүйлсийг тусгаж болох юм. Үүнд:

- Гэрээг байгуулах гол зорилго, гарах үр дүн;
- Гэрээг байгуулахад баримтлах зарчим, гол үйл ажиллагаа;
- Гэрээг байгуулах ажлын зохион байгуулалт, хариуцлага, тайлагналын зарчим;
- Гэрээний агуулгад оруулах асуудлуудын үндэслэл, хувилбар, эрэмбэ дараалал;
- Гэрээний хүрээнд компанитай харилцан тохирох үүрэг амлалтууд, хамтын шийдлүүдийн хувилбар;
- Гэрээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн зохицуулалтууд.



НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ: Хариуцлагатай уул уурхайн талаарх суурь мэдээлэл

Дараах нээлттэй цахим эх сурвалжуудаас уул уурхайн салбарын талаарх суурь ойлголтууд, нийгмийн хариуцлагын талаар дэлгэргүүлэн уншиж судлаарай:

Ашигт малтмал, газрын тосны газрын “Эрдэс баялгийн боловсрол” цахим мэдээллийн сан

<http://edu.mrpam.gov.mn/>

Д.Бямбажав ба бусад. Хариуцлагатай уул уурхай: Сургалтын гарын авлага www.undp.org/content/dam/mongolia/Publications/UNDP%20TRAINING%20MODULE%20ON%20RESPONSIBLE%20MINING%20IN%20MONGOLIA%20-%20MONGOLIAN.pdf

НҮБХХ. Уул уурхайн салбарын засаглалд хүрээлэн буй орчин ба хүний эрхийг нэгтгэх тухай Засгийн газар болон хамтрагч талуудад зориулсан гарын авлага www.undp.org/content/dam/undp/library/Sustainable%20Development/Environmental-Governance-Project/UNDP-MINING%20Summary%20Report%20MN.pdf

ХЯНАЛТЫН ХУУДАС: ГЭРЭЭ БАЙГУУЛАХАД БЭЛЭН ҮҮ?

Орон нутгийн удирдлага, гэрээг байгуулах эрх бүхий этгээдүүд гэрээг хэлэлцэх бэлтгэл ажлыг хэрхэн гүйцэтгэсэнээ дараах хяналтын хуудсыг бөглөх замаар үнэлж болно. Мөн энэхүү хяналтын хуудас нь олон нийтэд ил байвал зохих бөгөөд цаашид гэрээтэй холбоотой орон нутгийн зүгээс хийсэн ажлыг бодитой дүгнэх үндэслэл болно.

Хүснэгт 5. Гэрээ байгуулах бэлтгэлийг шалгах хяналтын хуудас

Асуулт	Үнэлгээ	Тэмдэглэл/Тайлбар
Хамтын ажиллагааны гэрээ байгуулах зорилго, шийдвэрлэх асуудлаа тодорхойлсон уу?	Тийм/Үгүй	
Уул уурхайн төслийн талаар хангалттай мэдээлэл авч чадсан уу?	Тийм/Үгүй	
Уул уурхайн төслийн нөлөөллийн бүс, гэрээнд хамрах ёстой орон нутгийн иргэд, нэгжийг тодорхойлсон уу?	Тийм/Үгүй	
Гэрээг байгуулах ажлын төлөвлөгөө гарсан уу?	Тийм/Үгүй	
Гэрээг байгуулах ажлын хэсгийн удирдамж, бүрэлдэхүүн, ажиллах нөхцөл болон ажлын хяналтыг зохион байгуулсан уу?	Тийм/Үгүй	
Гэрээг байгуулахад шаардлагатай мэдээллийг авч, түүнд шаардлагатай дүн шинжилгээ хийсэн үү?	Тийм/Үгүй	
Мэдээллийн ил тод байдлыг хангах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлж эхэлсэн үү?	Тийм/Үгүй	
Төслийн нөлөөлөлд өртөх талуудыг Сонсох ажиллагааг зохион байгуулсан уу?		
Гэрээг байгуулахад баримтлах зарчмуудыг тодорхойлсон уу?	Тийм/Үгүй	

ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОХ ҮЕ ШАТ



Д.Бямбажав “Үр дүнтэй хэлэлцэн тохиролцох нь”

<https://www.youtube.com/watch?v=jsN40q6ymw4>

Энэ үе шатанд хэлэлцээ хийхэд шаардлагатай дэмжлэгийг орон нутгийг төлөөлөх ажлын хэсэгтээ олгох, хэлэлцээ хийгч талуудын дунд болон иргэдийн дунд ойлголцол, итгэлцлийг бий болгох, мөн хэлэлцээ хийх тодорхой стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, гэрээнд тусгах суурь асуудлуудыг ойлгон, тохиролцоход онцгой анхаарах шаардлагатай.

ОЙЛГОЛЦОЛ, ИТГЭЛЦЭЛ БИЙ БОЛГОХ

Гэрээ байгуулахад оролцогч талуудын бүх ашиг сонирхол тэр бүр бүрэн хангагдахгүй байж магадгүй тул аль нэг тал сэтгэл дундуур үлдэх, улмаар гэрээ хэрэгжихэд хүндрэл учрах эрсдэлтэй. Тиймээс гэрээ байгуулагч талууд болон гэрээгээр эрх ашиг нь хөндөгдөх талуудын дунд ойлголцол, итгэлцлийн уур амьсгалыг бүрдүүлэх нь чухал. Энэ үе шатанд гэрээгээр шийдвэрлэхийг зорьж буй асуудалдаа төвлөрч, түүнийг хэрэгжүүлэх арга замуудыг талууд хамтран эрэлхийлж, гэрээнд тусгахад анхаарах хэрэгтэй. Харин хэлэлцээ хийж буй хүмүүс, тэдгээрийн тухайн асуудлаарх хатуу байр суурийг гэрээгээр шийдвэрлэхийг зорьж буй үндсэн асуудал, ашиг сонирхлоос илүүд тавихгүй байхад онцгой анхаарч, сэтгэл хөдлөл, уян хатан

бус байдлаас зайлсхийх хэрэгтэй. Үүнийг “асуудлыг хүнээс салгах” буюу “зарчимтай хэлэлцээ хийх” нэг чухал алхам гэж үздэг.³

Талууд хоорондын ойлголцлын зөрүүг арилгах буюу багасгах

- Төсөл болон компанийн талаарх мэдээллийг боловсруулах хангалттай хугацаа, чадавхтай байх;
- Төслийн цар хүрээ, эдийн засгийн үр ашиг, байгаль орчны сөрөг нөлөөлөл, орон нутагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөлөл зэрэг асуудлуудын талаарх ойлголтоо нэгтгэх;
- Аж ахуйн нэгжтэй хамтран төслийн цар хүрээ, үйл ажиллагаа, орон нутагт үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийн талаар олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Ажлын хэсгийн гишүүд бусдыг сайтар сонсох, хүндэтгэлтэй хандах, нэгдсэн ойлголцолд хүрэх зорилгыг ухамсарлах;
- Өмнө нь шийдэгдэлгүй явж ирсэн, ужгирсан эсвэл өмнөх лиценз эзэмшигчээс өвлөгдсөн асуудлуудын шалтгаан, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох.

Түр гэрээ байгуулах

- Төслийн талаарх мэдээлэл дутмаг, орон нутгийн захиргааны бэлтгэл хангагдаагүй, талуудын хооронд ойлголцлын зөрүү их үед Түр гэрээ (Харилцан ойлголцлын санамж бичиг, Харилцааны гэрээ, Үйл явцын гэрээ зэрэг) байгуулах нь үр дүнтэй байдаг.

³ “Тийм гэх хариуд хүрэх зам”, Рожер Фишер ба Уиллиам Ури, Харвардын хэлэлцээ хийх төсөл, 1991 он

Уг гэрээгээр дараах асуудлуудыг тохиролцох боломжтой. Үүнд:

- Орон нутгийн гэрээ байгуулах бэлтгэл ажил, түүнд зарцуулах хугацаа, хөрөнгө санхүү, мэдээлэл солилцоо;
- Талуудын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, харилцааны зарчим;
- Талуудын уулзалт, хэлэлцээний төлөвлөгөө;
- Олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа.



САЙН ТУРШЛАГА: Түр гэрээ байгуулах

2015 онд Өмнөговь аймаг, Ханбогд сумын Оюу Толгой компанитай Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Энэ гэрээг байгуулахаас өмнө нэгжээд түр гэрээг байгуулж талуудын хоорондын яриа хэлэлцээг тасралтгүй үргэлжлүүлж ирсэн байна. Түр гэрээ нь гэрээ байгуулахад сайтар бэлтгэх, олон нийт, орон нутгийн иргэдийн оролцоог хангах, хэлэлцээг үр дүнтэй явуулах зохион байгуулалт, харилцааны зарчмыг тодорхойлох давуу талтай. Нөгөөтэйгүүр, түр гэрээ нь хэт ерөнхий учраас үр нөлөө багатай байх эсвэл түр гэрээгээр тохиролцсон ажлууд хэрэгжээгүйн улмаас хамтын ажиллагааны гэрээг байгуулах ажил удаашрах зэрэг сул талтай.

ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОХ СТРАТЕГИ

Талууд байр суурин дээрээ хатуу зогсох тохиолдолд хэлэлцээ амжилттай болох магадлал бага. Тиймээс аль аль талын хүлээн зөвшөөрөх асуудлууд дээр анхаарч, эдгээр асуудлыг шийдэх арга замуудыг олж тохиролцох нь хэлэлцээ хийх чухал стратеги байх болно. Түүнчлэн талууд тухайн асуудлууд, тэдгээрийн шийдлийг хэлэлцэн тохирохдоо бодитой шалгууруудыг ашиглах нь чухал.

Шийдлийн хувилбарууд боловсруулах

- Хэлэлцээгээр тохирох гол зорилго, үр дүнгийн боломжит хувилбаруудын талаар саналууд гаргаж жагсаалт үүсгэх;
- Хамгийн боломжтой гэж үзсэн саналыг тодорхой зорилт, үйл ажиллагаа болгон тодорхойлж үр дүн, хэрэгжих боломж зэргийг харьцуулах;
- Хамгийн шилдэг хувилбарыг сонгох;
- Хэлэлцээ хийх явцад хэрэв хамгийн шилдэг “А” хувилбараар тохиролцох боломжгүй тохиолдолд “Б” буюу хоёр дахь хувилбар руу шилжих, дундын хувилбар эрэлхийлэх.

Тохиролцоонд хүрэхэд бодитой шалгууруудыг ашиглах

Хэрэв талуудын ашиг сонирхол их зөрүүтэй бол хэлэлцээ хийхэд тодорхой зарчмуудыг баримтлах нь оновчтой. Ингэснээр хоорондын харилцаагаа муутгахгүй байж, эцсийн үр дүнд хүрэх боломжтой. Үүнд:

- Тодорхой шалгууруудыг тогтох. Тухайлбал, хуулийн шаардлага, бусад гэрээнд асуудлыг шийдсэн байдал, компанийн чадавх, ёс зүй, бодитой статистик мэдээ зэрэг нь шалгуур байж болох юм. Тухайн асуудлыг шийдэхэд ямар шалгуур оновчтой байхыг хоёр тал тохиролцох хэрэгтэй.
- Асуудлыг шийдэх тодорхой шалгуурыг тохиролцож чадахгүй байгаа тохиолдолд шийдэх арга замыг тохиролцож болох юм. Тухайлбал, асуудлыг шийдэх саналыг нэг тал гаргах, гэхдээ түүнийг нь нөгөө тал нь заавал зөвшөөрсөн тохиолдолд тохиролцсонд тооцох, эсвэл дундын зуучлагч ажиллуулах зэрэг хувилбар байж болох юм.
- Нөгөө талынхаа ашиг сонирхлыг сонсох, тухайн асуудлаарх баримталж буй байр суурийн шалтгааныг асуух.
- Зарим тохиолдолд буулт хийх, шинэ мэдээлэлд тулгуурлан асуудлуудыг өөр өнцгөөс авч үзэхэд бэлэн байх нь зүйтэй.
- Шахалт, дарамт зэргээс эмээхгүй байх хэрэгтэй.

Уулзалт, хэлэлцээ хийх үеийн дотоод дүрэм мөрдөх

- Ажлын хэсгийг удирдан зохион байгуулагч нь бусад гишүүдэд хэлэлцээ хийхээс өмнө шаардлагатай мэдээллийг өгч, уншиж танилцах хангалттай хугацаа олгох;
- Ажлын хэсгийн гишүүд хэлэлцээний явцад баримтлах нэгдсэн байр суурьт хүрсэн байх;
- Уулзалтын ерөнхий төлөвлөгөөг гаргах, яриа хэлэлцээг уг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;
- Хэлэлцээний явцад гишүүдийн үүрэг тодорхой байх (хэн, хэзээ, юуны талаар үг хэлэх, нийтээрээ хэдийд санал солилцох зэрэг);
- Хэлэлцээний явцад ойлгомжгүй, эргэлзээтэй асуудал гарвал түр завсарлага авах, ажлын хэсэг дотроо ярилцаж тодруулах;
- Компанийн байр суурь, танилцуулгыг сайтар сонсох, тодруулсан асуулт асуух, орон нутагт давуу тал үүсэх нөхцөлийг эрэлхийлэх;
- Компанийн зүгээс шинээр дэвшүүлсэн саналд сэтгэл хөдлөлөөр хандахгүй, бэлтгэлтэй байх, багаар хэлэлцэж, судалж хариу өгөх;
- Хэлэлцээний тэмдэглэлийг дэлгэрэнгүй хөтлөх, хадгалах, дараагийн уулзалтад бэлтгэхэд ашиглах;
- Уулзалтын төгсгөлд хэлэлцэж тохиролцсон зүйлсээ тоймлон танилцуулах, дараагийн уулзалтаар хэлэлцэх асуудлаа тогтох;

- Гэрээг бүхэлд нь эцэслэн тохирох хүртэл санал нэгдсэн тодорхой асуудлууд бол эцсийн тохироо биш бөгөөд эргэж авч үзэх боломжтой байх.

Үр дүнтэй хэлэлцээ хийх

- Уулзалт, хэлэлцээг хамтран ажиллах гарц, асуудлын шийдлийг хайх боломж гэж хандах;
- Харилцан буулт хийх, удаах хувилбар, хамтын шийдэл хайх;
- Ээдрээтэй, хугацаа шаардсан асуудлыг дараагийн уулзалтаар хэлэлцэх буюу түр хойш тавих;
- Компанийн талаас захирал, дэд захирал буюу шийдвэр гаргах түвшний албан тушаалтныг оролцуулахыг шаардах;
- Хэлэлцээний явцад компанийн удирдлага, мэргэжилтнүүд өөрчлөгдөх, шинэ хүмүүс томилогдох явдал гардаг учраас хэлэлцээний тэмдэглэл, өмнө тохирсон үүрэг амлалтыг баримтжуулах;
- Компанийн зүгээс байгаль орчин, хүний нөөц, уурхайн үйл ажиллагаа зэрэг нэгжийн төлөөллүүдийг уулзалт, хэлэлцээнд оролцуулах;
- Уулзалт, хэлэлцээний талаар албан ёсны мэдээллийг олон нийтэд тогтмол өгөх, үүнд хэлэлцээний үндсэн агуулга, үр дүн, дараагийн алхмуудыг танилцуулах;
- Талууд нэгдсэн саналд хүрч чадахгүй тохиолдолд хэрхэх тухай тохирох.

ГЭРЭЭНД ТУСГАХ СУУРЬ АСУУДЛУУДЫГ ОЙЛГОХ

Хандив, мөнгөн тусламж

- Уул уурхайн төслийн үе шат, ашигт малтмалын төрөл, төслийн цар хэмжээнээс хамаарч гэрээнд хандив, тусламжийг оруулах эсэх, оруулбал Хүснэгт 2-т танилцуулсан хувилбаруудаас аль нь оновчтой болохыг шийдэх;
- Дотоод болон хөндлөнгийн санхүүгийн зөвлөхийн зөвлөмжийг авч үзэх;
- Хандив, тусламжийг хүлээн авах, хуваарилах, зарцуулах үр дүнтэй, оролцоонд суурилсан, ил тод механизмыг хэлэлцэн тохирч гэрээнд тусгах;
- Хандив, тусламжийг тусгайлан байгуулсан сангаар дамжуулан зарцуулах бол уг сангийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, шийдвэр гаргах, хяналт тавих тогтолцоо, ил тод байдал зэргийг гэрээнд тусгах;
- Сангийн зарцуулалт нь орон нутгийн хөгжлийн дунд болон урт хугацааны зорилтуудад чиглэсэн байх;
- Сангийн хөрөнгийг дэд бүтэц, хүний хөгжил, ЖДҮ-ийг дэмжих зэрэг тодорхой чиглэлд болон нөлөөллийн бүсийн хэмжээнд хэчнээн хувийг зарцуулахыг урьдчилан тохирч гэрээнд тусгах, тэдгээрт холбогдох журам, зохицуулалтыг боловсруулах;
- Сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэх хугацааг тодорхойлох;
- Сангийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнах хугацаа, хэлбэрийг тусгах;

- Сангаас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг тодорхойлох, шийдэхэд нөлөөллийн бүсийн иргэдийн саналыг авах боломжийг тусгах.

Хүснэгт 6. Хандив тусламжийг тооцох хувилбарууд

	Давуу тал	Сул тал
Хэлэлцэж тогтсон мөнгөн дүн	<ul style="list-style-type: none"> - Тогтсон хугацаанд орон нутагт тогтмол орлого орох - Хянахад хялбар - Аж ахуйн нэгжийн ашгаас хамаардаггүй. 	<ul style="list-style-type: none"> - Олборлолт нэмэгдэх үед орон нутгийн орлого нэмэгдэхгүй. - Ашигт малтмалын үнэ өсөхөд орлого нэмэгдэхгүй.
Олборлолтын хэмжээнээс хамаарсан мөнгөн дүн	<ul style="list-style-type: none"> - Аж ахуйн нэгж олборлолтоо нэмэгдүүлэхэд орон нутаг хүлээн авах орлого нэмэгдэх - Ашигт малтмалын үнэ буурахад орлогод нөлөөлөхгүй. - Аж ахуйн нэгжийн ашгаас хамаарахгүй 	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын үнэ өсөхөд орлого нэмэгдэхгүй. - Олборлолтын зардал буурахад орон нутагт ирэх орлого буурахаас гадна ажлын байр хомсдох.
Борлуулалтын хэмжээнээс хамаарсан мөнгөн дүн	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын үнэ өсөхөд орлого нэмэгдэх - Аж ахуйн нэгжийн ашгаас хамаарахгүй. - Аж ахуйн нэгжийн зардлаас хамаарахгүй. - Тодорхойлох, хянахад хялбар 	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын үнэ буурахад орлого багасах.

Аж ахуйн
нэгжийн
ашгаас
хамаарсан
мөнгөн дүн

- Аж ахуйн нэгжийн зардлаа хэмнэвэл орлого нэмэгдэнэ.
- Ашигт малтмалын үнэ өсвөл орлого нэмэгдэнэ.

- Төсөл болгон ашигтай байдаггүй.
- Ашигт малтмалын үнээс хамаарсан ашгийн хэлбэлзэл их.
- Үйл ажиллагааны зардал ихэсвэл орлого буурна. Ашгийн өмнөх хасалтуудыг ААН хийх эрсдэлтэй.
- Нягтлан бодох бүртгэлийн хяналт хийхэд нарийн төвөгтэй.
- ААН хөрөнгө оруулалтаа нөхөөд ашиг олох хүртэл хугацаа шаарддаг.

Хувь эзэмших

- Төсөл ашигтай үед орлого нэмэгдэнэ.
- Төслийн удирдлагын түвшинд мэдээлэл хүргэх, оролцох боломж бүрдэнэ.

- Хөрөнгө босгох шаардлага үүснэ.
- Төсөл ашиггүй байх эрсдэлтэй.
- Төслийн үйл ажиллагаанд тулгардаг эрсдэл тулгарна.
- Үйл ажиллагааны зардлын хэтрэлт, нэмэлт хөрөнгө оруулалтыг хариуцна.
- Богино хугацаанд орлого орж ирэхгүй байх.



“Орон нутгийн хөгжлийг дэмжих сангуудын туршлагаас”

Өмнөговь аймгийн туршлагаас <https://www.youtube.com/watch?v=jUqIw3eMGfA>

Ховд аймгийн туршлагаас <https://www.youtube.com/watch?v=Cx1M9ij6OC0>

Сүхбаатар аймгийн туршлагаас <https://www.youtube.com/watch?v=vWAlYRH1fwg>

Завхан аймгийн Дөрвөлжин сумын туршлагаас https://www.youtube.com/watch?v=e-MYn_7nHvwI

Төв аймгийн Заамар сумын туршлагаас <https://www.youtube.com/watch?v=pdAixzX-9B7A>

Ажил эрхлэлт

- Аж ахуйн нэгжийн хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөтэй танилцаж, орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих боломжуудыг тодорхойлох;
- Уул уурхайн төслийн хугацаанд орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийг дэмжсэн үүрэг, амлалтыг гэрээнд тусгахдаа хүний нөөцийн мэдээлэлд суурилсан, хэрэгжилтийг дүгнэх боломжтой тодорхой тоон дүн, хувь заах;
- Ажлын байрны тоо, хувийг тодорхойлж гэрээнд тусгахдаа уул уурхайн төслийн үе шаттай уялдуулах (хайгуул, бүтээн байгуулалт, олборлолт, нөхөн сэргээлт);
- Ажлын байрны тоо, хувийг тодорхойлохдоо тодорхой үе шаттай хэрэгжих, үе шат тус бүрийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэх боломжтой байх;

- Тодорхой бус, “аль болох”, “дэмжиж ажиллана” зэрэг бүрхэг үг хэллэг, үнэлж дүгнэх боломжгүй үүрэг, амлалтаас зайлсхийх;
- Ажлын эрхлэлттэй холбоотой гэрээний үүрэг амлалт биелээгүй тохиолдолд аж ахуйн нэгж ямар хариуцлага хүлээх талаар тусгах, тухайлбал орон нутгийн иргэдэд зориулсан мэргэжлийн боловсрол, сургалтын зардлыг нэмэгдүүлэх үүрэг хүлээх;
- Туслан гүйцэтгэгч компаниудад орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих шаардлага тавьж, үнэлж дүгнэх үүргийг гэрээнд тусгах;
- Орон нутгийн иргэдээс ажилд авахдаа тэднийг ажлын байрандаа суралцах, мэргэжлээ дээшлүүлэх нөхцөлтэйгөөр мэргэжлийн болон ажлын туршлагын хатуу шаардлага тавихаас зайлсхийх;
- Ажилд авах шалгуур, үнэлгээнд орон нутгийн иргэнд давуу нөхцөл олгосон заалт оруулах;
- Орон нутгийн иргэдэд мэргэжлийн боловсрол олгох, дадлагажих, мэргэжлээ дээшлүүлэх богино ба дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Уул уурхай эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш бусаар нөлөөлөх боломжтой тул илүү сөрөг нөлөөлж байгаа бүлэгт шууд болон шууд бус ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан сургалт, дадлагын хөтөлбөр хэрэгжүүлэх;

- Орон нутгийн иргэдийг ажилд авахдаа мэргэжлийн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын ёс зүйн (согтууруулах ундааны хэрэглээ, хөдөлмөрийн эрх, үүрэг, гэр бүлийн боловсролын) шаардлагын чиглэлээр сургалт хийх;
- Орон нутгийн ажилтнуудын хөдөлмөр эрхлэх таатай нөхцөлийг хангахад тодорхой арга хэмжээг тусгах, тухайлбал ажил, амралтын хуваарь
- Шинээр нээгдсэн ажлын байрны мэдээллийг орон нутгийн иргэдэд нээлттэй, шуурхай хүргэх арга, хэлбэрийг оновчтой сонгох;
- Ажлын байрны мэдээллийг зөвхөн зар мэдээллээр биш баг, хорооны уулзалтууд, нээлттэй өдөрлөг зохион байгуулах замаар өгөх;
- Орон нутгийн залуучууд ажилгүйдэлд өртөх магадлал өндөр тохиолдолд тэдэнд чиглэсэн сургалтын тэтгэлгийн хөтөлбөр хэрэгжүүлэх, ингэхдээ богино, дунд хугацааны мэргэжлийн сургалтууд, орон нутгийн хэрэгцээт мэргэжлийн чиглэлүүдийг харгалзах;
- Орон нутгийн их дээд сургууль, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран орон нутгийн иргэдэд хэрэгцээтэй мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжилд сургах, мэргэшил дээшлүүлэх.

Орон нутгийн бизнес хөгжил



Д.Бямбажав “Локал контент буюу орон нутгийн эдийн засгийн оролцоо”

https://www.youtube.com/watch?v=Yfph0e_82_k

- Уул уурхайн төслийн бараа, үйлчилгээ худалдан авах нөхцөлд орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд давуу тал олгосон шалгуур оруулах (тендерийн үнэлгээний оноо, үнийн зөрүүний хувь);
- “Орон нутгийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч” гэдэгт ямар нөхцөл, шалгуур тавих талаар хэлэлцэн нэгдсэн ойлголтод хүрэх;
- Орон нутгийн аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдийн мэдээллийн санг үүсгэх, уул уурхайн төслөөс худалдан авалт хийхдээ эхлээд орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд хандах буюу шалгаруулах, шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг орон нутгаас хангах боломжгүй бол гадагшаа хандах;
- Орон нутгийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн санхүү, хүчин чадал зэрэгт нийцүүлэн худалдан авалтыг нэг том багц гэрээгээр биш жижгэрүүлсэн буюу хэсэгчилсэн байдлаар хийх;
- Туслан гүйцэтгэгч компаниудад орон нутгаас бараа, үйлчилгээ худалдан авах тодорхой шаардлага тавьж, үнэлж дүгнэх үүргийг гэрээнд тусгах;

- Уул уурхайн төслийн худалдан авах үйл ажиллагааны журам, бараа үйлчилгээний талаарх мэдээллийг орон нутагт урьдчилан мэдээлэхдээ иргэд, аж ахуйн нэгжүүд саналаа ирүүлэх, үйл ажиллагаа төлөвлөх хугацааг бүрэн тооцох;
- Орон нутгийн аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг уул уурхайн төслийн стандартад нийцүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх;
- Орон нутгийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд зориулсан бизнесийг дэмжих сургалтууд зохион байгуулах;
- Орон нутгийн бизнес хөгжлийг дэмжих хамтарсан зөвлөл байгуулах, хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
- Жил, улирлын хамтарсан нээлттэй өдөрлөг, ханган нийлүүлэлтийн мэдээллийн арга хэмжээг зохион байгуулах;
- Уул уурхайн төслийн худалдан авалт, ханган нийлүүлэгч нарын мэдээллийг ил тод болгох, авлига, шударга бус байдлаас сэргийлэх;
- Орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн орлогыг дэмжиж бараа, үйлчилгээний төлбөрийг шуурхай шилжүүлэх;
- Уул уурхайн олон төсөл хэрэгждэг аймаг, сумдын хувьд орон нутгийн ЖДҮ-ийг дэмжих урт ба дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүнд уул уурхайн компаниудын

худалдан авалтын бодлогыг уялдуулах, орон нутгийн ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн компаниудын санхүүгийн ба санхүүгийн бус (мэдээлэл, технологи, зөвлөгөө) дэмжлэгийг нэгдсэн удирдлагаар хангах;

Дэд бүтэц

- Уул уурхайн төслийг хэрэгжүүлэх, олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай дэд бүтцийг барьж байгуулах, ингэхдээ байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс сэргийлэх үүрэг, амлалтыг тусгах;
- Уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явагдахаас өмнө түүнд шаардлагатай хатуу хучилттай автозам, төмөр зам, хяналтын гарц, гүүр, ус цэвэршүүлэх байгууламж зэрэг дэд бүтцийг барьж байгуулах;
- Уул уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай газар ашиглалт, дэд бүтцийн ажлыг явуулахад орон нутгийн иргэдтэй урьдчилан зөвлөлдөх, нөлөөллийн үнэлгээний дагуу иргэдийн эрхийг хамгаалах, нөхөн олговор, амьжиргааг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд зориулсан зам, дэд бүтцийг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд ашиглах боломжтой байх;
- Нийгмийн дэд бүтэц буюу эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх, ингэхдээ зөвхөн уурхайн ажилчдын гэсэн ялгарлыг үүсгэхээс зайлсхийж орон нутгийн нийт иргэдийн эрх ашиг, эв нэгдлийг хангах;

- Сургууль, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхэд хамтран хөрөнгө оруулах, тэдгээрийн тогтвортой үйл ажиллагааг хангахад орон нутгийн үүрэг хариуцлага тодорхой байх;

Байгаль орчин

- Байгаль орчны тухай хуулиудын заалтыг гэрээнд шууд тусгахаас зайлсхийж хуулиудын хэрэгжилтийг хангах, мөн орон нутгийн иргэдийн хяналт, оролцоог дэмжихэд чиглэсэн үүрэг амлалтыг тусгах;
- Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт зэрэг мэдээллийг орон нутгийн иргэдэд өгөх, санал авах;
- Уурхайн хог хаягдлын менежмент, хортой бодисын хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдал, гамшиг онцгой байдлын үед авах арга хэмжээний талаар иргэдэд мэдээлэл өгөх;
- Уурхайн хаалтын төлөвлөгөөг иргэдээр хэлэлцүүлж, саналыг тусгах;
- Орон нутгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хамтран хэрэгжүүлэх;
- Байгаль орчны нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаарх нээлттэй уулзалтууд хийх;

- Иргэдийн оролцоотой мониторинг хийх, тухайлбал усны чанар, түвшин, агаарын чанар зэрэг чиглэлд иргэдийн оролцоотой хяналт тавих, хуульч, шинжээч хөлслөн авах, дээж шинжилгээ авах гэх мэт холбогдох зардлыг хэрхэн санхүүжүүлэх механизмыг тусгах;
- Тоосжилт бууруулах, усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх талаарх төлөвлөгөө боловсруулах, төсөв хөрөнгө батлах, биелэлтийг хянах;
- Уул уурхайн нэгжгээд төслийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийх, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх хамтарсан зөвлөл байгуулах;
- Байгаль орчны асуудлаар иргэд, оролцогч талуудын гомдол, санал хүсэлтийг хүлээн авах тогтолцоог үр дүнтэй ажиллуулах.

Нийгмийн нөлөөлөл

- Хүн амын шилжих хөдөлгөөн ихсэж, суурин ба хөдөлгөөнт хүн ам өсөх үед нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмж доройтох эрсдэлтэй учраас эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмж, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх;
- Уул уурхайн төслийн шууд нөлөөллийн улмаас нүүн шилжихэд хүрсэн иргэдийн эрхийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эдийн засгийн хувьд өмнө байснаас дордохгүй байхаар амьдрах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Орон нутгийн малчдын тогтвортой амьжиргааг дэмжсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үүнд малын эрүүл мэнд, малчдын хоршоо, худаг усны хүрэлцээ, бэлчээрийн менежментийг онцлон үзэх.

ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд талууд мэдээллийг төлөвлөгөөтэйгөөр цуглуулж, түүнийгээ харилцан солилцох, хэрэгжүүлж байгаа ажил нь гэрээний зорилго, үүрэг амлалтыг биелүүлэхэд чиглэж байгааг үнэлэх, мөн гэрээ хэрэгжүүлэхийг зохих талууд зорьж ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулах, гэрээний биелэлтийг хянаж, алдаа оноогоо засах зэрэгт анхаарах шаардлагатай.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ БА СОЛИЛЦОХ

- Гэрээг батлан гарын үсэг зурсны дараа буюу хэрэгжүүлэх хугацаанд талууд хоорондоо албан ба албан бусаар мэдээлэл солилцох, зөвлөлдөх уулзалт хийх зэргээр байнгын харилцаа холбоотой ажиллах;
- Аж ахуйн нэгжийн бизнесийн нууцад хамаарахаас бусад бүтэц, өмчлөл, үйл ажиллагаатай холбоотой олон талын мэдээллийг олон нийтэд ил болгох;
- Гэрээний нөхцөл, үүрэг амлалтын хэрэгжилтийг хянах, дүгнэхэд шаардлагатай нарийвчилсан тоон мэдээллийг харилцан солилцох.

ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮҮРЭГ АМЛАЛТ БОЛОН ХИЙГДЭЖ БҮЙ АЖЛЫН УЯЛДАА

- Гэрээг ямар зорилтууд хэрэгжүүлэх буюу ямар үр дүнд хүрэхийн тулд байгуулсан нь тодорхой байх;
- Талуудын хооронд гэрээний зорилго, үр дүнгийн талаар нэгдсэн ойлголт бий болгох;
- Гэрээний үүрэг амлалтуудыг бүрхэг хэллэгээр биш биелэлтийг хэмжих, хянах боломжтой тодорхой тоон ба чанарын үзүүлэлтээр тодорхойлох;
- Гэрээний нөхцөл, үүрэг амлалтуудыг биелүүлэхийн тулд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бөгөөд түүнд шаардлагатай төсөв хөрөнгийг гэрээнд тусгах;
- Гэрээний үүрэг амлалт тасалдсан болон биелээгүй тохиолдолд хариуцлага тооцох зарчим тодорхой байх, тухайлбал орон нутгаас ажилтан авах үүрэг бүрэн хэрэгжээгүй бол түүнийг хөрөнгө оруулалт, худалдан авалт зэрэг өөр хэлбэрээр орлуулах.



САЙН ТУРШЛАГА: Тодорхой үүрэг, амлалтууд

Дорнод аймгийн Матад сум ба Петро чайна дайчин тамсаг компанийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний дагуу орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид болон малчид компанид бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлэх давуу эрх эдэлдэг. Худалдан авах бараа бүтээгдэхүүний талаарх мэдээлэл сумын мэдээллийн самбарт тогтмол тавигддаг байна. Дорнод аймгийн Дашбалбар сум ба Шинь шинь компанийн Хамтын ажиллагааны гэрээний дагуу компани нь орон нутгийн захиргаанд бүртгэлтэй ажилгүй иргэдээс 60-аас доошгүй тооны иргэдийг ажлын байраар хангаж, эрүүл, аюулгүй ажлын байрны нөхцөл бүрдүүлж, сарын цалинг 300000 төгрөгөөс доошгүй байлгах үүрэг хүлээдэг.

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ МЕХАНИЗМ

- Гэрээний талуудын харилцааг зохицуулах, гэрээний хэрэгжилтийг хянах, үр дүнд үнэлгээ дүгнэлт өгөх чиг үүрэг бүхий төлөөллийн тогтолцоо байгуулах;
- Гэрээний зарим бүлэг, үүрэг амлалтын хэрэгжилтийг хангахад чиглэсэн тусгай дэд хороодыг байгуулах;
- Гэрээний дагуу аж ахуйн нэгжүүдээс төлсөн мөнгө санхүүг зарцуулах сангийн үр дүнтэй, ил тод засаглалыг тодорхойлох.

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ

- Явцын ба үр дүнгийн мониторинг хэн хариуцаж, хэзээ хийх, үр дүнг хэрхэн тайлагнах талаар гэрээнд тодорхой тусгах, тухайлбал хамтарсан ажлын хэсэг, ИТХ, орон нутгийн Төрийн бус байгууллагаар мониторинг хийлгэх, гарах зардал гэх мэт.
- Гэрээний талууд, тэрчлэн иргэдийн төлөөлөл бүхий хамтарсан Ажлын хэсэг гэрээний үүрэг амлалтын (2 талын) биелэлтийг тогтмол үнэлж, зохих чиглэл, зөвлөмж гаргах.
- Гэрээний зорилт, үүрэг амлалтын хэрэгжилтийг тоон ба чанарын шалгуур үзүүлэлтээр үнэлэх, ингэхдээ шаардлагатай бол холбогдох мэргэжилтнүүдээс дэмжлэг тусалцаа авч болно. Тухайлбал, байгаль орчны үүргийн биелэлтийг үнэлэхэд орон нутгийн байгаль орчны байцаагчийн дүгнэлтийг авах гэх мэт.
- Маш олон орон нутгийн туршлагаас харахад гэрээний биелэлтийг зөвхөн компанийн гаргаж өгсөн тайлан мэдээнд тулгуурласан байх нь бий. Энэ нь гэрээний хэрэгжилтийг бодитойгоор дүгнэхэд учир дутагдалтай учраас захиргааны зүгээс гэрээний биелэлтийг дүгнэхэд шаардлагатай мэдээ баримтыг бүрдүүлэх хэрэгтэй. Тухайлбал, нийт ажилтнуудын тодорхой хувийг орон нутгаас авна гэсэн заалтын тухайд компани нийт хэдэн ажилтантай, тэрний яг хэдэн хувь нь орон нутгаас ажиллаж байгааг тогтоохын тулд компанийн нийгмийн даатгалтай холбоотой мэдээллийг авч тулган шалгах гэх мэт.

Хүснэгт 7. Гэрээний хэрэгжилтийг үнэлэх

Гэрээний зорилт	Гэрээний үүрэг амлалт	Биелэлтийн шалгуур үзүүлэлтүүд
Ажил эрхлэлтийг дэмжих		
Мэдээллийн ил тод байдлыг хангах		
Байгаль орчныг хамгаалах		
Орон нутгийн бизнесийг дэмжих		



САЙН ТУРШЛАГА: Иргэний нийгмийн мониторинг

Иргэний нийгмийн оролцоо: 2017 онд Ховд аймаг өмнө нь МоЭнКо компанитай байгуулсан орон нутгийн гэрээгээ шинэчлэх ажлын хэсэгтээ орон нутгийн иргэний нийгмийн төлөөллийг оруулжээ. Энэ нь 2015 онд Ховдын толь ТББ-ын хэрэгжүүлсэн мониторингийн төслийн үр дүн юм.


ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ нь гэрээ байгуулагч талуудын хооронд үүргийн харилцаа үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, гэрээний дагуу хүлээсэн тус бүрийн үүрэг, амлалтуудыг биелүүлэх, гэрээг бүхэлд нь үр дүнтэй хэрэгжүүлэх хамтын хүчин чармайлт гаргах шаардлага үүснэ. Харин гэрээний дагуу үүссэн үүргийг талууд өөрөөс шалтгаалах болон шалтгаалахгүй нөхцөл байдлын улмаас гүйцэтгээгүй бол зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас эдийн засгийн ба эдийн засгийн бус үр дагавар үүсдэг. Тийм учраас гэрээ байгуулахад гэрээний үүргүүд маш тодорхой байх, хэрэв үүргийн хэрэгжилттэй холбоотой бэрхшээл, талуудын маргаан гарвал хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой тусгаж өгөх шаардлагатай.

Түүнчлэн, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангахад талуудыг сахилга батжуулах зорилго бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгслийг гэрээндээ тусгаж болно. Үүнийг үүргийн гүйцэтгэлийг хангах арга гэх бөгөөд талуудын гэрээгээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилтийг хангах нэмэгдэл үүргийг гэрээнд тусгана гэсэн үг юм. Монгол Улсын Иргэний хуульд 9 дүгээр бүлэгт үүргийн гүйцэтгэлийг хангах аргын 6 үндсэн төрлийг хуульчилсан. Эдгээр нь орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд хэрэглэх боломжтой АНЗ юм.

Анз гэдэг нь хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тал нь гэрээний нөгөө талдаа төлөх ёстой мөнгөн төлбөр юм. Анзыг зөвхөн гэрээнд тусгасан буюу бичгээр урьдчилан баталгаажуулсан тохиолдолд хэрэглэж болно. Анз нь алданги болон торгууль гэсэн үндсэн 2

төрөлтэй бөгөөд нэг гэрээг тэдгээрийн аль нэгийг, эсхүл зэрэг хэрэглэж болох боловч нийт дүн нь гүйцэтгээгүй үүргийн 50 хувиас хэтрэх ёсгүйг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, компани орон нутгийн хөгжлийг дэмжих зориулалтаар жил бүр 50 сая төгрөгийн хандивыг 5 дугаар сард багтаан төлөх үүргийг гэрээгээр хүлээсэн гэж үзье. Гэтэл 2019 онд бүтээгдэхүүний олборлолт саатсан шалтгаанаар 30 сая төгрөгийг 5 дугаар сардаа багтаан төлжээ. Харин үлдэх 20 сая төгрөгийг тухайн жилийн 7 дугаар сард төлсөн байна. Энэ тохиолдолд хэрэв тухайн гэрээнд анз тооцохоор заасан бол түүний дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүрэг буюу хугацаа хэтрүүлж төлсөн 20 сая төгрөгийн 50 хувиас илүү байж болохгүй гэсэн үг юм.



Схем 4. Үүргийн гүйцэтгэлийг хангах аргууд

Алданги гэдэг нь хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг хэлнэ.

Торгууль гэдэг нь үүргээ гүйцэтгээгүй тал нь гэрээнд урьдчилан заасны дагуу гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн тодорхой хувиар төлөх анзыг хэлнэ.

ГЭРЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДАЛ

- Хамтын ажиллагааны гэрээ нь талуудын хоорондын хамтын ажиллагааны үндсэн механизм болохыг гэрээнд тусгах;
- Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах албан тушаалтан нь талуудын бүхий л харилцааг бүрэн төлөөлөхүйц эрх бүхий этгээд байх, ялангуяа компанийн талаас гүйцэтгэх захирал, түүнтэй дүйцэх албан тушаалтан буюу хууль, компанийн дүрмээр тухайн хуулийн этгээдийг төлөөлөх эрхтэй этгээд байх;
- Гэрээний дагуу байгуулагдах аливаа сан болон бусад бүтцийн үйл ажиллагааны зорилго, чиг үүрэг, зохион байгуулалтын үндсэн зарчмуудыг гэрээнд тусгаж харилцан хүлээх үүргийг баталгаажуулах.

ГЭРЭЭНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ БА ӨӨРЧЛӨЛТ

- Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа буюу эхлэх, дуусгавар болох хугацааг тодорхой заах (гэрээг 2 болон түүнээс олон жилийн хугацаатай байгуулах, ингэхдээ жил, улирал бүрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг гэрээнд хавсаргах);
- Гэрээг урт, богино хугацаагаар байгуулснаас үл хамааран тодорхой хугацаанд хэрэгжилтийг үнэлэн олон нийтэд мэдээлж, гэрээ болон түүний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлагыг тодорхойлох;

- Гэрээг өөрчлөх, цуцлах ерөнхий зарчмыг тусгах (цуцлах үндэслэл, түүний талаар нөгөө талдаа мэдэгдэх гэх мэт үйл явцыг тусгах);
- Гэрээг цуцлахаас аль болох зайлсхийж, талуудын хооронд үүссэн маргааныг аль болох яриа хэлэлцээ, харилцан ойлголцлоор шийдэх хувилбаруудыг тусгах;
- Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн улмаас гэрээг өөрчлөх, цуцлах, гэрээний гүйцэтгэлийг түр зогсоох үндэслэл, түүнд юуг хамруулах талаар тусгах (жишээ нь халдварт өвчин, үйлдвэрийн осол, байгалийн гамшиг, эдийн засгийн хэт тогтворгүй өөрчлөлт)⁴.

⁴ Давагдашгүй хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү. https://www.ubchamber.mn/uploads/Force_majeure_Hardship.pdf

ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ БА ХАРИУЦЛАГА

- Гэрээний дагуу хэрэгжих ажлууд, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн үүргийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангах талаар тодорхой үүргийг тусгах;
- Гэрээний хэрэгжилтийн явцад талуудын зүгээс ашиг сонирхлын зөрчил болон авлигын асуудалтай холбоотой зөрчил үүсвэл гүйцэтгэлийг түр болон бүрэн зогсоох хүртэлх арга хэмжээг авч болохыг тусгах;
- Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргааныг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох (хамтарсан ажлын хэсэг гаргах, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах, мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагч, арбитр, шүүх).

Хүснэгт 8. Хамтын ажиллагааны гэрээний маргаан шийдвэрлэх арга замууд ба харьцуулалт

	Зардал	Хугацаа	Шийдвэр
Хамтарсан ажлын хэсэг	Бага	Богино	Хамтын, уян хатан
Хөндлөнгийн шинжээч	Дунд	Дунд	Хөндлөнгийн, уян хатан
Эвлэрүүлэн зуучлагч	Дунд	Дунд	Хөндлөнгийн, хатуу, хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд хандах эрх нээлттэй
Арбитр	Их	Дунд	Хөндлөнгийн, хатуу
Шүүх	Их	Их	Хөндлөнгийн, хатуу

ЭХ СУРВАЛЖУУДЫН ЖАГСААЛТ

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хууль эрх зүйн үндсэн зохицуулалтууд

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан

Ашигт малтмалын тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63>

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

42.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

42.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.

42.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.

Засгийн газрын бүрэн эрх

9.1.10. энэ хуулийн 42.1-д заасан гэрээний загварыг батлах

Орон нутгийн хамтын ажиллагааны загвар гэрээ - <https://www.legalinfo.mn/annex/details/7245?lawid=11852>

Төсвийн тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/12254?lawid=12254>

Тусламжийн орлого

25.2. Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно:

25.2.1. эмнэлгийн үйлчилгээ;

25.2.2. бүх шатны боловсролын үйлчилгээ;

25.2.3. соёлын үйлчилгээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/397?law-id=397>

Шийдвэр гаргахтай холбогдсон хязгаарлалт

11.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.2. Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн

этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.3. Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны шийдвэр гаргахыг хориглоно.

Хандив авахтай холбогдсон хязгаарлалт

17.1. Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.

17.2. Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

17.3. Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

17.4. Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.

Захиргааны ерөнхий хууль - <https://www.legalinfo.mn/law/details/11259?lawid=11259>

Захиргааны үйл ажиллагааны хэлбэр

11.1. Захиргааны үйл ажиллагаа дараах хэлбэртэй байна:

11.1.1. захиргааны акт;

11.1.2. захиргааны гэрээ;

11.1.3. захиргааны хэм хэмжээний акт

Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч

13.1. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч /цаашид “оролцогч” гэх/ гэж захиргааны байгууллагад өргөдөл, хүсэлт гаргасан этгээд, захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээдийг ойлгоно.

13.2. Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцоно.

13.3. Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийг түүний хүсэлтээр, эсхүл захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, оролцогчийн зөвшөөрснөөр шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулна.

Оролцогчийн эрх

15.1. Оролцогч захиргааны байгууллагатай харилцахдаа дараах эрхийг эдэлнэ:

15.1.1. захиргааны шийдвэр гаргах ажиллагааны талаар хуульд заасан журмын дагуу мэдээлэл авах, холбогдох баримт бичгийг хуулбарлан авах;

15.1.2. тухайн захиргааны шийдвэрийг гаргах эрх бүхий албан тушаалтны талаар Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу мэдээлэл авах;

15.1.4. захиргааны шийдвэр гаргахаас өмнө оролцогч нотлох баримт гаргах, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгөх;

15.1.5. хэрэгжүүлэхийг хүссэн төсөл, үйл ажиллагаа, төлөвлөгөө, өргөдөл, хүсэлтийн талаар мэдээлэл авах;

15.1.6. хуульд заасан журмын дагуу захиргааны байгууллагын бүртгэл, архивын баримттай танилцах;

15.1.7. захиргааны байгууллагыг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийг шаардах;

Оролцогчийг сонсох

26.1. Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэнэ.

Орон нутгийн хамтын ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл

Байгаль орчны мэдээллийн сан - www.eic.mn

Гэрээ байгуулахад сонсох ажиллагаа зохион байгуулах, Нээлттэй Нийгэм Форум - http://forum.mn/index.php?sel=project&menu_id=469&obj_id=5246

Гэрээний мэдээллийн сан (Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан) - www.Iltodgeree.mn

Татвар, төлбөр, бусад мэдээллийн сан (Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын цахим тайлангийн систем) - <https://e-reporting.eitimongolia.mn>

Тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан (Кадастрын бүртгэлийн систем) - <https://cmcs.mr-pam.gov.mn/cmcs>

**ДАРААХ ХАЯГААР ХАНДАН ЦАХИМ ГАРЫН АВЛАГЫН АГУУЛГЫГ
САЙЖРУУЛАХ САНАЛАА ИРҮҮЛНЭ ҮҮ**



http://forum.mn/index.php?sel=content&obj_id=5881